

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл:	1-4
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-29

1.Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 02 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан төсөл, анхны хэлэлцүүлэг/

4-8

2.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын 8 гишүүн 2026.04.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

8-29

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны
4 дүгээр сарын 29-ний өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 32 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 59.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 34 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Р.Сэддорж, П.Батчимэг, М.Энхцэцэг;
Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Ганбаатар;
Тасалсан: Р.Батболд, Ш.Бямбасүрэн, Б.Пунсалмаа, О.Цогтгэрэл.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан хуралдаан даргалагч Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн Худалдаа аж үйлдвэрийн танхимын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай асуудал болон хэлэлцэх асуудлын дарааллын дөрөвдүгээр асуудал болох “бусад” гэсэн асуудлуудыг хойшлуулав./15:35/

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуу үг хэлэв.

Нэг.Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 02 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан төсөл, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх С.Тэнгис, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газрын дарга Ж.Аюуш нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, мөн албаны зөвлөх Б.Нандингэрэл, референт Б.Галсанбат, М.Мандхай, Х.Шижир нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэхийг дэмжье гэсэн горимын санал гаргав.

С.Цэнгүүн: Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүний гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	14
Татгалзсан:	9
Бүгд:	23

60.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 02 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын 8 гишүүн 2026.04.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, мөн албаны зөвлөх Б.Нандингэрэл, референт Б.Галсанбат, М.Мандхай, Х.Шижир нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат, Д.Үүрийнтуяа, Б.Мөнхсоёл, Б.Жаргалан, М.Мандхай нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэ нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат, О.Батнайрамдал, Д.Үүрийнтуяа, Г.Уянгахишиг, М.Мандхай, С.Цэнгүүн нар үг хэлэв.

С.Цэнгүүн: 1.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 10
Бүгд: 24
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 9
Бүгд: 24
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 19
Бүгд: 24
20.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 15 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 41 минут үргэлжилж, 32 гишүүнээс 24 гишүүн хүрэлцэн ирж, 75.0 хувийн ирцтэйгээр 17 цаг 15 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Р.СЭДДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим
15 цаг 34 минут.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

С.Цэнгүүн: Эдийн засгийн байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя.

Чинбатын Анар, Болдын Жавхлан, Жаргалсайханы Золжаргал, Баатаржавын Мөнхсоёл, Агваанлуvsангийн Ундраа, Саруулсайханы Цэнгүүн, Доржсүрэнгийн Үүрийнтуяа, Отгоншарын Батнайрамдал, Батбаярын Жаргалан, Ганзоригийн Лувсанжамц, Ганбатын Очирбат, Болдын Уянга, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан, Хүрэлбаатарын Булгантуяа, Батжаргалын Заяабал, Загджавын Мэндсайхан, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Гончигдоржийн Уянгахишиг, Сүхбаатарын Эрдэнэбат нар танхимд хүрэлцэн ирсэн байна.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 59.4 хувь хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2026 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1.Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 2 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

2.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг нарын 8 гишүүн 2026 оны 4 сарын 9-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх.

3.Байнгын хорооны тогтоолын төсөл “Ажлын хэсэг байгуулах тухай”.

4.Бусад гэсэн 4 асуудал хэлэлцэхээр энэ 7 хоногийн тов дарааллыг Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөлөөс баталсан байна.

Үүнээс Худалдаа аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх эсэх асуудлыг шийдвэрлэх үеэр Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг уг асуудлаар 5 хоногийн завсарлага авсан тул энэ хуулийн төслийг Байнгын хороо, чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хэсэг байгуулах тухай асуудлыг өнөөдрийн хуралдаанаас хойшлуулж байна.

Мөн “бусад” гэсэн асуудлын хүрээнд хэлэлцэх асуудлын талаар тодорхой чиглэл, мэдээлэл ирээгүй тул өнөөдрийн хэлэлцэх асуудлаас түр хойшлуулж байна.

Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу?

Ч.Лодойсамбуу: Лодойсамбуу гишүүн.

Түр 30 секундийн дараа дахиад авчхаж болох уу? Энэ хэлэлцэх асуудал маань гар дээр ирээгүй байна.

С.Цэнгүүн: Лодойсамбуу гишүүний микрофоныг өгье.

Ч.Лодойсамбуу: Гишүүддээ өдрийн мэнд хүргэе. Өнөөдөр бас өглөө 8 цагаас даргын дэргэдэх зөвлөл бас хуралдсан. Өнөөдөр бас 8 цагаас Монгол Улсын Засгийн газар хуралдсан. Ингээд Байнгын хороодын хурлаар хэлэлцэх асуудал орж ирж байгаа асуудлууд ,тэгээд дахиад даргын дэргэдэх зөвлөлөөр удахгүй бас хэлэлцэх асуудлыг тов дараалалд багтаагүй хууль, тогтоолын төслүүд ингээд ер нь энэ Их Хурлын хэлэлцэж байгаа ингээд асуудлыг харахаар баахан албан тушаал томилгоо, эс үгүй бол Хянан шалгах түр хороо, баахан шүүх хурлын асуудал ярьдаг болчихоод байна.

Тэгээд өнөөдөр Засгийн газрын хуралдааныг бас их сонслоо, хүлээлээ. Нөгөө татвар, нийгмийн даатгалын асуудал яасан бэ? Татварын багц хууль гээд өргөн барьсан гишүүд санаачлаад миний бие олон гишүүдтэй хамтраад Нийгмийн даатгалын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл, манай Баярмаа гишүүн Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл гээд өргөн барьсан. Эхнээсээ жил гаруй болж байна. Хэлэлцдэггүй, хэлэлцүүлдэггүй. Засгийн газар бодлогоо оруулж ирнэ гээд 2 дахь жил рүүгээ орж байна. Өнөөдөр Засгийн газрын хуралдаанаар бас шийдэл алга.

Шинэ Ерөнхий сайд томилогдоод 1 сар болж байна. Яг 1 сар болж байна. Энэ татварынхаа асуудлуудыг, нийгмийн даатгалынхаа асуудлуудыг яг ойлгохгүй байгаа юм уу, томьёолж чадахгүй байгаа юм уу? Энэ хэлэлцэх асуудалд энэ яг одоо хэрэгцээтэй байгаа, хэзээнээсээ хойш хүлээж байгаа, энэ олон жил хүлээж байгаа энэ олон нийтийнхээ энэ хүлээлтэд байгаа сэдвүүдээ оруулж ирээч ээ энэ хуулиудаа. Төрийн ордны гадаа жишээлбэл тэтгэврийн асуудал яриад ахмадууд жагсаад бараг сар боллоо. Хоолойгоо сөөтөл хашхирч байна. Тэтгэврийг 1 сая 500 мянган төгрөг болгооч ээ гэж байгаа юм. Энэ шаардлага бол үнэхээр хэцүү шаардлага.

Гэхдээ энийг эрүүлээр сонсвол ард талд нь бид нарын орлого ерөөсөө энэ амьжиргаанд хүрэлцэхээ болилоо гэдэг их хашхираан явж байна шүү дээ. Сүүлийн 1 сарын хугацаанд бид нар махныхаа үнэтэй нүүр тулаад одоо эхнээсээ яаж яг яаж болгоод байгаа юм бэ, яаж болгох юм бэ гэдэг энэ нөхцөл байдал гадаа гудамжинд байна шүү дээ. Айл өрх болгонд. Тэгээд өрхийн амьжиргаагаа яаж сайжруулах юм? Энэ махны үнэ өсөх нь ойлгомжтой болчихсон зудын шалтгаантай, нийлүүлэлт нь багассан гээд өнгөрсөн оны 11 дүгээр сард бид нар сануулаад ярьж байсан. Энэ үед яаж өрхийн орлогыг хамгаалах юм бэ, бодит амьжиргааг нь яаж тэтгэх юм бэ гэдэг бодлогоо бодож байх ёстой нь Засгийн газар, Их Хурал.

Өрхийн амьжиргааны тухай яг бодож байгаа яг энэ Засгийн газрын гишүүд, энэ Ерөнхий сайд, Ерөнхийлөгч, Их Хурлын гишүүд байна уу яг үнэндээ яг одоо?

Яаж хэн нэгэнд хариуцлага тооцох вэ, яаж хэнийг зодож нүдэх вэ, яаж хэнийг хааш нь томилох вэ, яаж төрийн өмчийн компаниудаа нааш цааш нь болгох вэ ийм л юм бодож байна. Яг энэ гадна талд юу болж байгааг бүр ингээд амьдралаас тасарчихдаг юм уу 12 жил засаглахаараа? Гайхаад байна л даа бид нар ингээд хуулиа өргөн бариад жил гаруй болоод хэлэлцэхгүй тэгээд өөрсдөө оруулж хэлэхгүй болохоор яг гайхаад байна. Тэгээд өнөөдрийн Засгийн газрын хуралдаанаас их хүлээлттэй байлаа. Ядаж ирэх 7 хоногоос бид нар энэ татварын асуудлуудаа хэлэлцээд эхлэх юм байна. Ийм хүлээлттэй байсан. Байхгүй. Тэгээд одоо энэ Байнгын хороо дээр хэлэлцэх гэж байгаа асуудлуудыг нь харъя. Ямар ч ийм амьдралд шууд нөлөөтэй өчнөөн олон жил хүлээж байгаа энэ сэдвүүд алга байна шүү дээ.

С.Цэнгүүн: Лодойсамбуу гишүүн санал хэлсэн үү?

Хэлэлцэх асуудал нэг, Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг Монгол Улсын Их Хурлын гишүүн Отгоншарын Батнайрамдал танилцуулна. Гишүүний микрофоныг нээнэ үү.

Ажлын хэсгийг танилцуулъя. Ажлын хэсгийн гишүүд С.Тэнгис Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх, Ж.Аюуш Монгол Улсын бүртгэлийн Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газрын дарга. Батнайрамдал гишүүний микрофоныг нэе.

О.Батнайрамдал: Эдийн засгийн байнгын хорооны 2026 оны 4 сарын 21-ний өдрийн 2 дугаар тогтоолоор Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 2 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг 5 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулагдаж ажиллалаа.

Ажлын хэсгийн ахлагчаар Батнайрамдал миний бие, ажлын хэсгийн гишүүдээр Улсын Их Хурлын гишүүн Батсүмбэрэл, Очирбат, Пунсалмаа, Эрдэнэбат нарын гишүүд ажиллалаа.

Улсын Их Хурлаас 2024 оны 4 сарын 19-ний өдөр батлагдаж, 2025 оны 1 сарын 1-ний өдрөөр мөрдөгдөж эхэлсэн Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн холбогдох зүйл, заалтад Мэргэжлийн нэгдсэн холбоог үүсгэн байгуулсан бол Улсын дээд шүүхэд бүртгүүлэхээр заасан нь шүүхийн үндсэн чиг үүрэг, мөн чанарт харшилсан гүйцэтгэх эрх мэдлийн чиг үүргийн асуудлыг шүүх эрх мэдлийн байгууллагад хариуцуулсан нь Үндсэн хуулийн эрх мэдлийг хуваарилах зарчимтай зөрчилдөж байна гэж үзэж Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 2 дугаар дүгнэлтээр Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.3 7.4 дэх хэсэг, 8 дугаар зүйлийн 8.1, 8.2, 8.3, 8.4, 8.6, 8.7 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг нь Үндсэн хууль зөрчсөн гэж дүгнэсэн.

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг 2026 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж хүлээн зөвшөөрсөн тухай Улсын Их Хурлын тогтоол батлагдсан.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.3 дахь хэсэгт заасны дагуу Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөн бол ажлын 14, 15 өдрийн дотор тухайн болон холбогдох бусад хууль, тогтоомж, шийдвэрт зохих нэмэлт, өөрчлөлт оруулна гэж заасны дагуу ажлын хэсэг 2026 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр 100 хувийн ирцтэй хуралдаж Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөлд Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1, 6.2, 6.4 дэх хэсэг, 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.3, 7.4 дэх хэсэг, 8 дугаар зүйлийн 8.1, 8.2, 8.3, 8.4 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт заасан Улсын дээд шүүх, Улсын дээд шүүхийн Тамгын газар гэснийг Улсын бүртгэлийн байгууллага гэж өөрчиллөө.

Мөн хуулийн 8.6, 8.7 дахь хэсгийг өөрчлөн найруулж, мэргэжлийн нэгдсэн холбоог Улсын бүртгэлийн байгууллага бүртгэхдээ өрсөлдөөний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон бусад этгээдээс тайлбар авах, нэмэлт баримт бичиг, лавлагаа, мэдээлэл гаргуулах, шинжээч томилох, ажиллуулж болно гэж мэргэжлийн нэгдсэн холбоог бүртгэхдээ холбогдсон журмыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална гэж тус тус өөрчлөн найрууллаа.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Ажлын хэсгээс боловсролын хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье.

С.Цэнгүүн: Ажлын хэсгийн танилцуулгаас асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү?

Алга байна. Гишүүд асуулт асууж дууслаа.

Одоо ирцэд орсон гишүүд танхимд цуглахыг хүсье. Санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Саналын томьёолол.

Хуулийн төслийн талаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдээс санал ирээгүй тул Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.24 дэх хэсгийг үндэслэн хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэхийг дэмжье гэсэн саналын томьёолоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал Хураалтад 23 гишүүнээс 14 гишүүн зөвшөөрч, 60.9 хувиар энэ саналыг дэмжигдлээ.

Санал хураалт явуулж дууслаа.

Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал танилцуулна.

Хуулийн төслийг хэлэлцэж дууслаа. Дараагийн асуудалд орёе.

16.02 цаг

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулъя.

Хуулийн төслийн талаарх танилцуулгыг хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг танилцуулна. Гишүүний микрофоныг нээнэ үү. 3 номерын микрофон.

П.Сайнзориг: Хурал даргалагч, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 24-өөс 28 оны үйл ажиллагааны хөтөлбөрт төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулах зорилтыг тэргүүлэх чиглэл болгон тус хөтөлбөрийн 3.1.2.4-д төрийн болон орон нутгийн өмчит компаниудын засаглал ил тод байдлыг сайжруулж, олон улсын менежментийн багаар удирдуулж, нээлттэй хувьцаат компани болгон үр ашиг, баялгийг тэгш хуваарилалтыг нэмэгдүүлнэ гэж. Мөн хөтөлбөрт төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагын нэгдмэл байдлыг хангах төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийг улс төрөөс хараат бус, нээлттэй, ил тод, зах зээлийн зарчмаар үйл ажиллагаа явуулах тогтолцоог бүрдүүлнэ ээ гэж тус тус зорилтыг дэвшүүлсэн.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 21 оны 106 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан Шинэ сэргэлтийн бодлогын 6.4-д төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үр ашиг, засаглалыг сайжруулж, олон нийтийн шууд хяналтад оруулах ажлыг зохион байгуулна гэж заасан.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас гаргасан 23 оны тоон мэдээллээс үзэхэд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд 99 байгаагаас төрийн өмчит хуулийн этгээдийн төрийн өмчит үйлдвэрийн газар 17 байна. Төрийн болон орон нутгийн өмчит компанийн удирдлагыг хэрэгжүүлэхэд үр ашиггүй зардал гаргахгүй байх, мэргэжлийн байх, санхүүгийн төлөвлөгөөний дагуу ажиллах хариуцлага, эрх, үүргийн хувьд бие даасан байх зарчмыг хангах нь чухал бөгөөд дээрх зарч зарчим нь төрийн өмчит үйлдвэрийн газарт үйлчлэх эсэх нь тодорхойгүй байна.

Нөгөөтээгүүр Иргэний хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан ашгийн төлөө хуулийн этгээдийг нөхөрлөл компани хэлбэрээр байгуулна гэж заасан бөгөөд төр засаг, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж болох аймаг, сум, дүүрэг, дүүрэг нь иргэний эрх зүйн харилцаанд хуулийн этгээдийн нэгэн адил оролцох хуулийн зарчимтай.

Гэтэл Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар дээрх хуулийн үзэл баримтлалтай зөрчилдсөн төрийн өмчит үйлдвэрийн газар хэмээх статус бүхий

засаглал, хуулийн этгээдийн хэлбэр талаасаа ойлгомжгүй бүтэц өнөөдрийг хүртэл одоо үйл ажиллагаа явуулах нөхцөл бүрдсээр байна.

Өөрөөр хэлбэл, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу явагдах дээр үйл ажиллагаанаас хамаарч Монгол Улсын бодлогын бичиг баримтууд туссан дээрх зорилтууд хангагдах эсэх асуудал, хуулийн этгээдийн нээлттэй байдлын асуудал, энэ асуудлууд ойлгомжгүй өнөөдрийг хүрч байна.

Хуулийн төсөлд эдгээр үйлдвэрийн газруудаас ашгийн төлөө хуулийн этгээдийн компани хэлбэрт оруулж, цаашид төрийн өмчит үйлдвэрийн газар статустай хуулийн этгээд шинээр байгуулахгүй байхад чиглэж байгаа болно.

Мөн төр орон нутагт хувьцаа эзэмшигчдийн эрхийг ард түмнийг төлөөлөн хэрэгжүүлж байгаагийн хувьд энэхүү онцлог байдалд нийцсэн ил тод хяналттай эдийн засгийг зохицуулах үзэгчийн чиг үүргээ хувьцаа эзэмшигчийн чиг үүргээсээ салангид хэрэгжүүлэх боломжийг олгосон эрх зүйн зохицуулалтыг бий болгох шаардлагатай гэж үзэж байна.

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн хариуцлага эрх, үүргийн хувьд улс төрөөс ангид, хараат бус байх, үр ашигтай, хараат бусаар хөндлөнгийн хяналттай байх нь компанийн үйл ажиллагаа цаашдын үр ашигт чухал бөгөөд компанийн үйл ажиллагаа ил тод байх, компанийн нэр, төр, эсвэл бизнесийн нэр хүнд орон нутгийн хүлээх үүргийг хариуцахгүй байх зарчим мөн хуульчлах шаардлага байна.

Мөн хуулийн төсөлтэй холбоотойгоор дагаж мөрдөх журмын хууль болон 91 оны 1 дүгээр сарын 4-ний өдөр баталсан Бүгд Найрамдах Монгол Улсын Засгийн газарт эрх олгох тухай хуулийг хүчингүй болгох хуулийн төслийг дагалдуулан боловсруулсан.

Төрийн болон орон нутгийн өмчит компанийг олон нийтийн болгох үйл ажиллагааг эрчимжүүлэн дэмжих нөхцөл бүрдүүлэх, үнэт цаасны зах зээлд оролцогчийн хөрөнгө оруулалт, итгэлийг хамгаалах, төрийн өмчийг үнэгүйдүүлэхгүй байх, менежментийг ил тод хариуцлагатай хийх нөхцөлийг бүрдүүлэхэд дээрх хуулийн төслүүд нь зорьж байгаа болно.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийг хэлэлцэхийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье.

С.Цэнгүүн: Ажлын хэсгийг танилцуулъя. Цэнддаваагийн Баяр-Эрдэнэ Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга.

Хуулийн төслийн талаар хууль санаачлагчаас асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү?

Үүрийнтуяа гишүүнээр тасалъя. Эрдэнэбат гишүүний микрофоныг нээе.

С.Эрдэнэбат: Төрийн өмчийн хуулийн гол үзэл баримтлал нь засаглалыг сайжруулах гэж бол байгаа. Тэгэхээр сүүлийн 30 жилийн хугацаанд өмч хувьчлал, төрийн өмчийн компаниудын засаглалыг харахаар бас нэг зүйл бас дутуу

харагдаад байдаг юм. Дотор, дотоод засаглал буюу тухайн компанийн засаглалд голцуу төрийнхөн өөрсдөө орж эхэлсэн. Магадгүй манай ихэнх, яам тамгын газрын зарим голлох яамдын дарга нар бол хэдэн ч төрийн өмчийн компанийн ТУЗ-д байдаг юм би бол мэдэхгүй. Тэгээд бүгдээрээ яг суперменүүд л юм шиг байгаа юм гэж би бол хараад байдаг юм зарим талаараа.

Нөгөө талаараа хараат бус энэ тэр гээд гишүүдээр ингээд овоо юм бодож байгаад оруулаад ирсэн зарим хараат бус гишүүд нь хамгийн их ашиг сонирхолтой, хараат, хэн нэгэн хүнээс хамааралтай хараат байдлаар бас байх гээд байдаг ийм зүйл байдаг. Тэгээд үндсэндээ энэ юу болдог вэ гэхээр улс төрийн циклээр ч гэдэг юм уу, янз бүрийн циклээр тэнд байгаа байгууллагын хамт олон мэдлэг чадвартай, ур чадвартай ийм ажилчид нь бол бас гаргах гэдэг ийм эс эрсдэл бас нэлээн нүүрлэсэн байдаг.

Тэгэхээр би энийг юу гэж хэлэх гээд байна вэ гэхээр энэхүү хуульдаа Сайнзориг гишүүн маань бас энийг бол би дэмждэг гишүүний гэж би ойлгодог. Тэнд байгаа ажилчдад тодорхой хувьцааг нь олгох гадаад, дотоодын бас туршлагууд байдаг. АНУ-ын ... гээд хөтөлбөр бол манай Монгол улсад бас хэрэглэж үзэх гэж байгаа тэгээд ерөөсөө болоогүй. Тэгээд энийг энэ хуульдаа энэ оруулсан уу, судалсан уу, одоо хууль хэлэлцэх шатад оруулаад хийгээд явбал яадаг юм бэ гэдэг.

Өөрөөр хэлбэл, ажил хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүсийг урамшуулах хэрэгтэй байна. Дотоод хяналтыг нь өөрөө өөрсдөөр нь хийлгэмээр байна. Өөрөө өөрийнхөө тогооноосоо хулгай хийх юм бол өөрийнх нь үр өгөөж буурна. Би илүү их үр ашигтай ажиллаж байж энэ компанийн 1 ч гэсэн эрэг шуургыг хайрлаж, гамнаж, эс үгүй бол тэр дотор байгаа янз бүрийн болохгүй, бүтэхгүй удирдлага, менежмент, алдагдлыг бууруулж байж би үр шимээ хүртэх юм аа гэдэг энэ ойлголтыг бий болгох юм бол энэ бол маш нэлээн том өөрчлөлт гарах болов уу гэдгийг бол. Хувийн компаниуд бол хийгээд эхэлчихсэн. Түлхүүр ажилчдадаа хувьцаа өгдөг, урт хугацаанд нөхцөлтэй тэр тэтгэврийн даатгалыг нь өгдөг, өөрийнхөө давуу эрхийн хувьцаануудыг өгдөг. Энэ нь өөрөө 1 дүгээрт боловсон хүчин тогтвор суурьшилтай, нөгөө талаар бол компанийн засаглалд бол маш их үр өгөөжтэй ийм зүйл байдаг. Тэгээд энэ тал дээр ямар санаа оноо байна вэ хуулийн төсөл дээр оруулбал ямар вэ гэдэг зүйлийг бол би бас хэлмээр байна.

Хоёрдугаарт компаниудыг хувьчлах хувийн хэвшлийн оролцоо тодорхой хэмжээнд оруулж ирэхийг бол бас зүйтэй. Гэхдээ орж ирэхгүй байгаа шалтгаан юу вэ? Тухайлбал, банкнууд дээр 20 хувийг 1 хүн эзэмшинэ гээд. Ер нь яах вэ төрийн гэлтгүй манай хувийн компаниуд ч гэсэн ер нь бол олон нийтийн болох энэ зүйл нь явахгүй байгаад байгаа шалтгаан шалтгаан юу байдаг юм бэ гэдэг зүйлийг бол асуумаар байна.

С.Цэнгүүн: Хууль санаачлагч Сайнзориг гишүүний микрофоныг нээе. 3 номер.

П.Сайнзориг: Бас Эрдэнэбат гишүүнтэйгээ ер нь санал нэг байгаа. Миний энэ одоо өргөн барьж байгаа яах вэ Төрийн болон орон нутгийн өмчит өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах асуудал маань ер нь энэ Иргэний хууль, дээрээс нь Монгол Улсын бодлогын бичиг баримтад тусгагдаад байгаа энэ төр, аж ахуй эрхлэхтэй холбоотой ямар төрлийн хуулийн этгээд байгуулж болох юм бэ? Энэ байгуулсан хуулийн этгээдийн засаглал, ил тод байдлыг хангахад ямар арга

хэмжээнүүдийг авахаар төлөвлөсөн юм бэ гэдэг энэ зорилтуудыг л хангахын тулд явж байгаа юм.

Ер нь таны бас асуултад дурдагдаж байгаа олон асуудлыг цогц байдлаар нь шийдэхийн тулд Засгийн газраас өргөн барьсан Нийтийн өмчийн тухай хууль болон Төрийн болон орон нутгийн өмчид компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах хууль дээр бид нар иж бүрнээр нь ярьж болно. Энийг бол дэмжиж байгаа. Энэ хуулийн төсөл бол цаашдаа одоо байгаа энэ иргэний суурь хуулийн үзэл баримтлалтай нийцэхгүй, дээрээс нь наад захын дотоод энэ хяналтуудын бүтэц ажиллах эсэх нь тодорхойгүй ийм хуулийн этгээдүүдийг ер нь хааж өгье өө л гэдэг зүйл байж байгаа.

Засгийн газраас өргөн барьсан тэр хуулийн төслийг болдог бол энэ хаврын чуулгандаа баталмаар байна. Мэдээж хэрэгжих хугацаа шууд батлагдсаны дагуу хэрэгжих боломжгүй байгаа. Тийм учраас наана урьдаж энэ төрийн өмчит үйлдвэрийн газруудыг компанийн хэлбэрт дор хаяж шилжүүлээч ээ гэдэг зүйлийг л тавьж байгаа юм.

Өнөөдөр ТУЗ гэдэг бол үндсэндээ компанийн дунд хугацааны болоод хуульд заасан зарим чиг үүргүүдийг баталгаажуулахаасаа гадна ер нь бас хяналтын бүтэц шүү дээ. Дээрээс нь компанийн бүтцэд бас дотоод аудитын болоод комплайнсын нэгжүүд ажиллах бололцоотой. Тэгэхээр төрийн өмчит үйлдвэрийн газар дээр энэ ажиллах эсэх нь бас тодорхойгүй байна.

Мэдээж дараагийн бас хяналтын асуудал чинь эргээд хувьцааг нь бас олон нийтэд буюу зөвхөн төр эзэмшээд байх олон нийтийг оруулж бас энэ хяналтыг сайжруулах энэ үр өгөөжөөс бас бүгд хүртэх энэ зарчмыг баримтлах ёстой. Мөн таны ярьж байгаа бас тухайлан хувьцааг давуу эрхийн хувьцаа байх уу энгийн хувьцаа байх уу энэ бол бас тодорхой кэйс болгон дээр ярьж болно. Энэ асуудлыг ажилчинд бас тодорхой олгох энэ асуудал байж болно. Энэ асуудлыг бол манай хувийн зарим компаниуд бол хэрэгжүүлээд явдаг юм шүү дээ. “АПУ” ХК бол бас тодорхой боловсон хүчний тогтвор суурьшилтайгаас гадна хяналтыг бас хэрэгжүүлэх үүднээс бол ингээд хэрэгжүүлээд явж байгаа.

Тэгэхээр энэ зүйлүүдийг бол бас зайлшгүй өндөр ур чадварын мэргэжилтнүүд бас ажилладаг энэ салбарууд дээр илүү тохиромжтой юм шиг байна лээ. Энийг хувийн хэвшилд гэдэг юм уу, яах вэ зүгээр энэ гадагшаа бас боловсон хүчний урсгал бас гарчхаад байгаа энэ үе дээр бол тогтоон барих үүднээс бол уг нь бас өгдөг, дээрээс нь бас хяналтыг сайжруулаад явдаг ийм таны ажилтанд бас хувьцааг нь энэ хувьцаа нь энгийн байх уу, давуу эрх байх уу тусдаа асуудал. Бараг өглөө гэхэд бас тодорхой хэмжээний хяналт бол сайжирдаг, үр ашиг сайжирдаг, ашиг нэмэгддэг гэсэн ийм тодорхой сайн жишээнүүд бол байгаа.

Тэгээд мэдээж энэ төрийн өмчит компаниудыг бас олон нийтийн болгох, биржээр арилжаалахад бас саад учруулж байгаа нэг зүйл бол Банкны хуулийг дагаад маш том буруу ойлголт, зохицуулалт орчихсон. Тодорхой юу гэдэг юм нэгдмэл гэдэг юм уу ашиг сонирхол, хамаарал бүхий этгээдүүд тухайн компанийн 5-аас дээш хувийг эзэмших боломжгүй болгоод хаячихсан. Тэгээд энэ өөрөө эргээд бас тодорхой хэмжээний энэ өмч хувьчлалыг гэх үү, өмч хувьчлал гэж ярьж болохгүй олон нийтийг бас энэ хувьцааг нь төрийн өмчит болон орон нутгийн өмчит компанийг бас санал болгох, биржээр арилжаалахад бас томоохон саад болчихоод байгаа. Энэнээсээ ч болоод энэ банкны гэдэг юм уу төрд байгаа энэ

банкны хувьчлалууд ч гэсэн тийм сайн үр дүнтэй хэрэгжиж чадахгүй байгаа гэдэг нь бол нууц биш. Тэгээд ер нь энэ иргэний хуулийнхаа суурь концепцид нийцүүлж энэ хуулийн этгээдийн төрөл хэлбэрийг бий болгоё оо л гэсэн ийм санаагаар энэ хуулийн төсөл явж байгаа. Тэгээд таны бусад саналуудыг Засгийн газрын өргөн барьсан тэр төрийн өмчийн багц хууль дээр бид хэд ярилцаад шийдээд явах бололцоотой.

С.Цэнгүүн: Эрдэнэбат гишүүн тодруулж асууя.

С.Эрдэнэбат: Компанийн хууль маань өөрөө бас одоогийн яг хууль, эрх зүйн хувьд бол бас учир дутагдалтай нэлээн юмнууд бол байгаа. Төрийн өмчийн компаниудыг үйлдвэрийн газруудыг компани болгоод ингээд нэгдмэл нэг стандарт руу нь оруулахыг нь бол дэмжиж байна. Компанийн хуулиа дагаад бас засаж янзлахгүй бол бас төрийн өмчийн компаниудыг яг одоогийн Компанийн тухай хуулиудаар ингээд явуулахаар таарах, таарахгүй асуудлууд байгаа. Төрийн өмчийн компани маань өөрөө нийгмийн шинж чанартай төрийн өмчийн компаниуд бас байдаг тийм үү. Тухайлбал, нийтийн тээвэр ч гэдэг юм уу, өөр бусад станц ч гэдэг юм уу тэгээд энэ зүйлийг бол давхар бас харж үзээрэй гээд. Өөрөөр хэлбэл, Компанийн тухай хуулийг ер нь бол яг энэ хууль хэрвээ батлагдвал дагаж зайлшгүй өөрчлөх, сайжруулах ийм бол шаардлага бол байгаа гэдгийг бол хэлмээр байгаа юм.

С.Цэнгүүн: Санал хэллээ. Батнайрамдал гишүүний нэрийг нэмье. Мөнхсоёл гишүүний нэрийг бас нэмье. Үүрийнтуяа гишүүн.

Д.Үүрийнтуяа: Сайнзориг гишүүн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт орохоор бас нэр бүхий гишүүдтэй хамт хуулийн төсөл өргөн барьсан байна. Тэгээд өнгөрсөн хаврын чуулганаар Засгийн газраас Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг шинэчилсэн найруулга хэлбэртэйгээр Нийтийн өмчийн тухай хууль, төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн анхдагч хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн барьчихсан, хэлэлцэх эсэх нь дэмжигдчихсэн. Бид ажлын хэсэгт хамтдаа ажиллаж байгаа.

Тэгэхээр энэ таны оруулж ирсэн хуулийн төслийг харахаар одоо Компанийн хуульд ч тэр, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд ч тэр байхгүй төрийн өмчит үйлдвэрийн газар гэсэн нэршилтэй энэ нэршлүүдийг цэгцлэхээр оруулж ирж байна л гэж харж байна л даа. Тэгэхээр энийгээ энэ хуультайгаа хамтад нь аваад явчхаж болохгүй байсан юм уу? Дагасан хууль 1991 оны БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хуулийн хувьд Цэнгүүн гишүүн бас өргөн бариад өнгөрсөн бараг чуулганаар шахуу санагдах юм хэлэлцэх эсэх нь дэмжигдээд явж байгаа шүү дээ. Тэгэхээр яагаад энийг ингээд давхардуулах шаардлага байгаа юм бол? Хууль санаачлагчийн хувьд эдгээр хуулийг нэгтгээд явах боломжгүй юу? Уг нь манай ажлын хэсэг энэ оны 1 сард байгуулагдсан. Тэгээд та хуулийн төслөө 4 сарын 9-нд өргөн барьсан юм байна. Тэгэхээр энэ дээр ямар нэгэн зайлшгүй анхаарах, тусад нь авч үзэх шаардлагатай зүйл байгаад байна уу? Хэрэв тийм бол тэр ямар асуудал дээр тусгайлан хуулийн төсөл бэлтгэх шаардлагатай байгаа гэдэг дээр тодорхой нөхцөл байдлыг нь та бас тодорхой болгож хэлж өгөөч?

С.Цэнгүүн: Хууль санаачлагч Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Зарчмын асуудлыг бол ойлгож байна аа. Ер нь нэгтгээд явж болно. Агуулга тэнд бас ер нь тусаж байгаа. Тэгэхдээ юу хэлэх гээд байна гэхээр тэр Нийтийн өмчийн хууль болон төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийг бас батлах энэ процесс нэлээн бас үргэлжлэх төлөвлөлттэй байна. Болдог бол энэ хаврын чуулган ингээд баталлаа гэхэд энэ хууль бол батлах шаардлагагүй байж болно.

Тэгэхдээ аливаа ийм том хуулийн реформ бол бас хэрэгжих цаг хугацаа, хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажил гэж байдаг. Тэр хуулийг баталлаа ч гэсэн тодорхой хагас жилийн хугацааг дор хаяж өгч таарах байх. Тэгэхээр би бол энэ хуулиараа энэ Иргэний хуулийн суурь концепцтой нийцэхгүй байгаа, засаглалын хэв тодорхойгүй байгаа энэ хуулийн этгээдийг 1 өдөр ч гэсэн явуулж боломгүй юм аа л гэж үзэж байгаа юм. Аль болохоор компанийн засаглалыг бүрдүүлж, бид хэдийн ярьдаг, мэддэг тэр нээлттэй сонгон шалгаруулалтаар мэргэжлийн хүмүүсийг баг компанийг удирдуулах, энэ ард түмний өмчийг үр ашигтай эдийн засгийн эргэлтэд оруулж үр өгөөж нь буцаад ард түмэнд хүрдэг байх энэ асуудал дээр 1 хоног ч гэсэн цаг хугацаа алдах шаардлагагүй. Энийг бол бас наана ч гэсэн шийдээд явж байх ёстой гэж үзэж байгаа.

Хоёрдугаарт, Засгийн газраас өргөн барьчхаад байгаа энэ өмч хувьчлалын жагсаалтууд байгаа. Төрийн өмчийн өмч хувьчлалын жагсаалт. Эдгээр өмч хувьчлалыг амжилттай болгоё гэвэл засаглалын хувьд яг хуулийн хүрээнд бий болгож байж энэ өөрөө ил тод, үр бүтээмжтэй, үр дүнтэй ажиллаж байж энэ өмч хувьчлал чинь бас зөв явна аа. Тэгэхээр энийг бас наана нь л бас цэгцлэх ёстой юм аа гэдэг л энэ гол зорилгыг, сигналыг, энэ мэдрэмжийг л олон нийтдээ өгье гэдэг зорилгоор бас явж байгаа.

Энэ тэгэхээр агуулгын хувьд бас бие биетэйгээ давхцаж байгаа мэт боловч цаг хугацааны хувьд бол бас яг хамтдаа хэрэгжих энэ бололцоо нь яадаг бол гэдэг дээр л би эргэлзэж энэ хуулийн төслийг явсан. Гишүүдийн бас хууль санаачлах энэ бас энэ тэр дээр бас цаг хугацааны юм явсаар байгаад араас нь орж ирж байгаа. Цэнгүүн гишүүн маань бас дагаж байгаа хууль дээр буюу энэ бас компанийн засаглалыг бас алдагдуулж байгаа, ил тод байдлыг алдагдуулж байгаа ийм БЭТ-ийн хуулийг бид хэдийн нэршлээр бол БЭТ-ийн гээд байгаа 91 хуулийг бас хүчингүй болгохоор өргөн барьсан юм байна лээ. Энэ дээр бол би бас мөн адил санал нэгтэй байдаг.

Ер нь цаашдаа цаашдаа ингэж компанийн засаглалыг алдагд дуулсан стандарт бус шийдвэр гэдэг юм уу энэ нь өөрөө эргээд л ард түмэнд бас тийм эргэлзээ үүсгэхээд байна. Эргээд энэ бас менежментийг ч гэсэн тодорхой цаг хугацаанд зөв байх боловч ер нь алсдаа буруу жишиг үлдээгээд байна аа гэдэг зүйлээр л энэ өөрчлөлтийг цаг алдалгүй наана ч гэсэн хийе ээ л гэдэг байдлаар энэ хуулийн төслүүдийг нэр бүхий гишүүдтэй өргөн барьчхаад байгаа юм аа.

С.Цэнгүүн: Үүрийнтуяа гишүүн тодруулж асууя.

Д.Үүрийнтуяа: 2 шаардлага хэлж байх шиг байна. Тэгэхээр зарчмын хувьд бол нэгтгээд явах боломжтой гэдэг дээр санал санал нэгдэж байгаа бол энэ нийтийн өмчийн хууль болон төрийн өмчит компанийн засаглал, ил тод бүтээмжийг дээшлүүлэх хуулиа хаврын чуулгандаа батлуулна гээд бид шахаад ажиллавал энэ нь үр дүнтэй биш үү? Энэ ажлаа шахаад ажиллахад бол бидэнд болохгүй, боломжгүй зүйл байхгүй болов уу гэж бодож байна.

Манай Сайнзориг гишүүн, Номинчимэг гишүүдийн хувьд бол бас энэ хуулийн төслүүд дээр шуурхай ажиллаж хэлэлцүүлгүүдийг зохион байгуулаад миний хувьд бол бас нэлээн шуурхай явж байгаа гэж ойлгож байгаа. Харьцангуй бас энэ дээр асуудлууд үл ойлголцох гэдэг юм уу зарчмын асуудлууд гайгүй болов уу гэж бодоод байгаа шүү дээ. Тэгэхээр энийгээ шахаад явчихвал яасан юм? Цаг хугацааны хувьд л асуудал байна гэж үзэж байгаа юм байна.

Тэгэхээр хаврын чуулганаар энэ асуудлаа оруулаад явчихвал яг энэ хуулийн үзэл баримтлал, үндсэн агуулга, хөндөгдөж байгаа зарчмууд нь нэг байгаа үед дахин хуулийн төсөл болгож оруулах нь ямар байдаг юм бол доо. Та хууль санаачлагчийн хувьд татаад авчхаж болохгүй юу? Өмч хувьчлалтай холбоотой үзэл баримтлалыг.../минут дуусав./

С.Цэнгүүн: Үүрийнтуяа гишүүнд 1 минут.

Д.Үүрийнтуяа: Өмч хувьчлалын тухайд бол өмч хувьчлалын жагсаалт гэж би ойлгохгүй байгаа Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэх эсэхийг нь дэмжсэн асуудал бол бид өмч хувьчлалын үзэл баримтлалыг хэлэлцсэн гэж ойлгож байгаа. Тэгэхээр энэ дээр бас ард иргэдийн дунд тийм үл ойлголцол яваад байгаа юм. Энэ үнэхээр бид нар үзэл баримтлалыг хэлэлцэж үү, эсвэл өмч хувьчлалын хувьчлах жагсаалтыг хэлэлцээд байгаа юм уу гэж? Тэгэхээр энэ чиглэлээр Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар бас тодорхой хариулт өгөөч гэж хүсэж байна.

С.Цэнгүүн: Хууль санаачлагч Сайнзориг гишүүний микрофоныг нээе.

П.Сайнзориг: Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын газрын дарга бас сүүлийн асуултад хариулъя. Ямар ч байсан хуулийн төслөө бол холбогдох Байнгын хороо болон чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэх нь зөв байх. Би бол аль болохоор Үүрийнтуяа даргатай санал нэг байгаа. Хаврын чуулганаар энэ төрийн өмчийн багц хуулийг батлуулахыг хичээнэ, өөрөөсөө шалтгаалах зүйлийг хийнэ. Тэгэхээр хувь гишүүн бол та бид 2 бас түмэн эрмэлзэлтэй ч гэдэг юм уу чин эрмэлзэлтэй байхад энийг эцэслэн батлах асуудал маань Улсын Их Хурлын бүрэн эрхийн асуудал байгаа. Ажлын хэсэг маань 25 хүний бүрэлдэхүүнтэй байгаа. Нийтийн өмчийн хуулийн ажил маань яаж явахыг би бас хэлж мэдэхгүй байгаа. Тийм учраас өнөөдөр ард түмний хамгийн үнэ цэнтэй өмчүүд энэ төрийн өмчит компаниуд буюу байх ёстой энийг зөв менежмент хийх ёстой байтал төрийн өмчит үйлдвэрийн газар гэсэн өнөөдөр ойлгомжгүй бөгөөд тайлбарлахад хэцүү социалист эрх зүйн тогтолцооноос үлдсэн энэ ойлголт хүртэл ингээд яваад энийг бид ашиглаад тодорхой энэ хуулийн этгээдүүд ингээд ажиллаад.../минут дуусав./

С.Цэнгүүн: Ажлын хэсгийн 2 дугаар, 1 дүгээр микрофон.

Ц.Баяр-Эрдэнэ: Үүрийнтуяа гишүүний асуултад хариулъя. Төрийн болон орон нутгийн өмчийн хуулиар бол Улсын Их Хурал өмч хувьчлалын үндсэн чиглэл гэдэг энэ бодлогын баримт бичгийг батлах ёстой. Тэгээд энэ үндсэн чиглэлийн төслийг бол Их Хуралд өргөн мэдүүлсэн байгаа. Их Хурлаас батлагдсан үндсэн чиглэл бол үндсэндээ 4-өөс дээш жилийн өмнө хугацаатай батлагддаг. Тэрийг нь тухайн тухайн жил Засгийн газар ямар компаниудаа тэр арга хэлбэрээр нь олон нийтийн болгох вэ гэдэг хувьчлах вэ, худалдах вэ гэдэг дээрээ бол жагсаалт гаргаад явдаг ийм үндсэн бодлогын баримт бичиг байгаа.

Өөрөөр хэлбэл, Их Хурал бол хувьчилж үл болох жагсаалт гэдэг нэг бодлогын баримт бичиг батална. 4-өөс дээш жилийн үечлэлтэй үндсэн чиглэл гэдэг ийм бодлогын баримт бичиг батална. Тэгээд энэ бодлогын баримт бичиг Их Хурал дээр хэлэлцэгдээд дэмжигдсэн байгаа. Үүнд бол уул уурхай, эрчим хүч, бусад чиглэлийн нэр бүхий компаниудыг дийлэнхийг нь биржээр олон нийтэд нээлттэй санал болгох хэлбэрээр туссан байгаа.

С.Цэнгүүн: Энэ асуудалтай бас холбоотойгоор ер нь энэ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг Сайнзориг гишүүн болон 8 гишүүн хамтран өргөн барьсан байгаа. Миний хувьд бол БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хуулийг хүчингүй болгохоор 12 сарын 30-ны өдрөөр өдөр бол өргөн барьсан. Энэ төрийн өмчит, Төрийн болон орон нутгийн өмчит тухай хуульд бол өөрчлөлт оруулах энэ хууль маань бол 4 сарын 9-нд өргөн баригдсан байгаа. Тэгэхээр цаг хугацааны хувьд бол 2 өөр үед өргөн баригдсан байгаа.

Миний үзэж байгаагаар бол ер нь сөрөг хүчний гишүүний өргөн барьсан буюу хууль санаачлах эрхээ эдлээд явж байгаа учраас би бол ажлын хэсгийг бол нэгтгэх саналыг бол дэмжихгүй байгаа. Тэр утгаараа бол бас Байнгын хороо болон чуулганаар хэлэлцэх нь батлагдаад явсан учраас тусдаа хэлэлцүүлэгдээд явах нь зүйтэй юм аа гэдэг бол байр суурьтай байгаа гэдгээ бас Үүрийнтуяа гишүүнд бас хэлье.

Батнайрамдал гишүүн.

О.Батнайрамдал: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг бол зарчмын хувьд бол дэмжиж байна. Гэхдээ нэг зүйлийг хэлье. Ер нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хууль сүүлийн 20 жилийн турш нэмэлт, өөрчлөлт оруулна, шинэчилсэн найруулга явуулна гээд 20 жил болж байгаа хууль. Хууль шүү дээ тээ. Маш их ярьдаг боловч өнөөдөр яг батлагдсан, эсвэл анхныхаа хэлэлцүүлэгтээ орчихсон юм байхгүй л байгаа шүү дээ.

Тэгэхээр ер нь зарчмын хувьд бол энэ хууль дээр өөрчлөлт оруулах гэж байгаа, энэ хуулийг зөв болгох гэж байгаа алхам болгоныг бол зарчмын хувьд бол дэмжинэ гэж бодож байгаа. 20 жил ярьсан хууль байхгүй юу. Өнөөдөр Монгол дээр, Монгол Улсад явж байгаа энэ их хулгай, хулгай гэж ярьсаар байгаад хэдэн их наядаар ярьдаг болсон. Бүгдээрээ явж явж дандаа л төрийн болон орон нутгийн өмчтэй холбоотой, тэр компаниуд дээр гарсан үйл явдалтай л холбоотой шүү дээ.

Тэгэхээр өнөөдөр төрийн өмчит үйлдвэрийн газар гээд энэ концепцоо өнөөдөр “Эрдэнэт” үйлдвэр төрийн өмчит үйлдвэрийн газар, нөгөө талаасаа Монгол улсын их сургууль бас төрийн өмчит үйлдвэрийн газар шүү дээ. Үгүй ээ энэ чинь ингэж болох юм уу тээ? “Эрдэнэт” үйлдвэр, Монгол улсын их сургууль 2-ын хооронд нэг ёсондоо статусын хувьд бараг адилхан хэмжээнд авч явагдаж байна шүү дээ. Тийм тэгээд эндээс бол угаасаа асуудалтай гэдэг нь бол маш ойлгомжтой.

Тийм учраас энэ хуулийг бол зарчмын хувьд бол дэмжиж байна. Ер нь энэ хуультай холбоотой, энэ хуулийг бид нар өөрчилж байж л сууриар нь энэ их асуудлуудыг өөрчлөн цэгцлэх боломжтой болно гэж бодож байгаа юм. Их

сургуулиудтай бараг 2 жилийн өмнө уулзаж байсан. Тэгтэл бүх их сургуулиуд төрийн өмчит үйлдвэрийн газар гэдэг статустай гэхэд тухайн үедээ бүүр гайхаж байсан байхгүй юу. Энэ чинь манай уул уурхайн салбар дээрх компаниуд чинь төрийн өмчит үйлдвэрийн газар гэж явдаг шүү дээ. Тэгэхээр энэ статусын хувьд ч гэсэн ийм толгой эргэсэн ийм олон асуудалтай бид нар байгаа нь үнэн. Энийг үүгээр нь байлгах ч сонирхол маш их байдаг.

Тийм учраас ер нь цаг хугацаа алдахгүйгээр иймэрхүү асуудлуудаа шийдээд явах нь бол би бол хувьдаа бол дэмжиж байна. Дагалдан хуулиар орж ирсэн хууль тэр БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хууль тусдаа хууль болоод ингээд яваад ингээд явчхаж болно шүү дээ. Аль алиныг нь дэмжих саналаа ч гэсэн өгсөн. Тэгэхээр хамтдаа тэгээд явчхаж, тус тусдаа ингээд явчхаж болно л гэж харж байгаа юм. Дээрээс нь Засгийн газар дээр бас Засгийн газар биш Улсын Их Хурал дээр Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн тухай хууль 2 дэд ажлын хэсэг гараад нэгтгээд Үүрийнтуяа гишүүн ахлаад явж байгаа тээ.

Тэгэхээр энэ ч гэсэн бас нөгөө том зураглалаар нь шинэчилсэн найруулгаар бас шийдээд л явах ёстой. Гэхдээ цаг хугацаа алдах тусам тэр чинь алдагдсан боломжийн өртөг болж гарч байгаа шүү дээ. Дандаа өмч эзэмшигч нь болохоор дандаа ард түмэн гэсэн хаягтай. Нэмэлт 1 минутаа авчихъя.

С.Цэнгүүн: Батнайрамдал гишүүнд 1 минут.

О.Батнайрамдал: Тэгэхээр татвар төлөгчдийн өмч гэсэн үг. Тэрний захиран зарцуулалтын асуудал л энэ дээр шийдэгдэх гээд байна шүү дээ. Тийм болохоор ийм энэ оролдлого болгоныг бол дэмжинэ. Хийх л ёстой байхгүй юу. Харин бас нэг зүйл нь 20 жилийн турш энэ хууль энэ танхимд 20 жил яригдсан шүү дээ. Энэ хуулийг өөрчилнө л гэдэг шинэчилнэ л гэдэг.

Гэхдээ одоогийн байдлаар огт шинэчлэгдээгүй л явж байгаа байхгүй юу. Тэгээд үүний үр дүндээ их сургуулиа хамгийн том үйлдвэртэйгээ нэгтгээд л төрийн өмчит үйлдвэрийн газар гэдэг статустай явж байгаа нь бол яг үнэнийг хэлэхэд гадаад хүнд ярих юм бол итгэмээргүй л зүйл байгаа байхгүй юу. Тийм учраас асуулт бол алга. Хуулийг бол зарчмын хүрээнд дэмжиж байгааг илэрхийлье.

С.Цэнгүүн: Санал хэллээ. Мөнхсоёл гишүү.

Б.Мөнхсоёл: Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд ер нь төрийн өмчит компаниудтай холбоотой асуудлууд олон жил яригдсан өмнөх гишүүд бас хэлж байна. Ялангуяа дандаа алдагдалтай ажилладаг тэгээд улс төрийн болон сонгуулийн үеэр хамтарч ажилласан тусалж дэмжсэн хүмүүсээ хүний нөөцөд нь оруулдаг, ингээд чадамжгүй байдал үүсдэг. Одоо энэ байгаа янз бүрийн төрийн өмчит компаниуд “Эрдэнэс Монгол” энэ тэр гээд дандаа асуудал дагуулдаг аа. Засаглалыг нь сайжруулна гээд явдаг тэгэхдээ л асуудал бүрэн гүйцэд шийдэгддэггүй гэх мэт ингээд маш олон учир шалтгаан асуудлын улмаас Төрийн өмчийн компанийн тухай хууль гэж ажлын хэсэг үүсчихсэн байгаа шүү дээ. Ил тод байдал, бүтээмж, засаглалын асуудал гэснээ товчлоод нэр бүхий тэгээд дотроо 2 дэд ажлын хэсэг үүссэний нэг нь тэр өөрийн чинь хэлж байгаа Нийтийн өмчийн тухай хуулийн ажлын хэсэг шүү дээ.

Тэгээд би өчигдөрхөн энэ хэлэлцүүлэгт оролцсон манай Сайнзориг гишүүн ахлаад Үүрийнтуяа гишүүн, Номинчимэг гишүүн 2 сууж байсан болохоор би тэр ажлын хэсгийг гэж бодоод суугаад байсан шүү. Тэгээд үнэхээрийн дажгүй хэлэлцүүлэг болсон. Азийн хөгжлийн банкны гадаад зөвлөх ирж танилцуулгаа хийсэн. Тэр дээр 5 чухал малгайн асуудлыг хөндсөн. Засаглал, ил тод байдал, бүтээмж, тэгээд ТУЗ, бусад нөгөө ашигт ажиллагаа тэгээд төрийн өмчит компаниудыг ерөнхийдөө бид нарын нөгөө дандаа эргэлздэг, арилжааны болон арилжааны бус гэж 2 тэр янзаар байгуулж болно гээд маш их ийм том бүтцийн шинжтэй асуудал яригдсан.

Дүгэржав гээд хуульч яг энэ Үүрийнтуяа гишүүний ахлаад байгаа тэр ажлын хэсэгт бас зөвлөх үйлчилгээ үзүүлээд байгаа компанийн төлөөлөл шүү дээ. Тэр хуульч бас нөгөө төрийн өмчит компаниудын бүтэц олон улсын түвшинд ямар байдгийг ярьсан шүү дээ гээд ингээд яг давхцалтай байгаа байхгүй юу. Миний хүртэл толгой эргэчихсэн явж байна. Тэгэхээр би бол Үүрийнтуяа гишүүнтэй ерөнхийдөө төстөйдүү санал хэлэх гээд байна. Ингээд 1 хуулиар асуудлаар 2, 3 ажлын хэсэг гарах ч юм уу давхцалтай явахаар дотор нь байгаа би хүртэл төөрчихсөн бүх юманд нь оролцоод явж байна шүү дээ. Энэ чинь одоо 1 асуудал шийдэх гээд байгаа юм. Нэг нь нөгөөдөө шингэчихсэн байгаа. Яг ингээд хил гааль ингээд хүрээгээрээ яг ... нөгөө хамрах хүрээ нь под гээд тэнцэхгүй ч гэсэн нь нөгөөдөө шингэчихсэн асуудал шүү дээ.

Тэгээд засаж залруулахгүй бол давхар юмаа яриад байхаар чинь өрөөсгөл л дөө. Замбараагүй байдал үүсэхийн шинж дохио шүү дээ. Тэгээд энэ дээр ийм санал байна надаа нэгтгэсэн нь дээр ээ, татаж авна уу, яана уу зэрэг зэрэг төстэй ажлын хэсгүүд уралдан ингээд үүсээд байгаад би угаасаа анхнаасаа анхнаасаа жоохон сэтгэл өвдөж явдаг шүү дээ нөгөө сэдвийн өмчлөл, уралдаан, өрсөлдөөн бол дэмий илүүц юм аа хамтрах ёстой юм аа гэдэг дээр дотоод, гадаадгүй хэлээд явдаг гишүүдийн нэг байгаа юм аа. Ийм саналтай байна.

С.Цэнгүүн: Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Гишүүдийнхээ саналыг бол хүндэтгэж байна. Тэгээд бас агуулга бол төстэй. Тэгэхдээ төрийн өмчийн реформ гэдэг бол зөвхөн энэ төр ямар төрлийн хуулийн этгээд байгуулах вэ гэдэг асуудлаас гадна маш өргөн хүрээний асуудлыг бид бид нар цогц реформ хийх гээд явж байгаа. Тэр хууль батлагдахыг маш их хүсэж байгаа хүний нэг нь би өөрөө байгаа. Тантай бас яг санал нэг.

Тэгэхдээ зүгээр батлагдлаа ч гэсэн хэрэгжих цаг хугацаа, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнөөсөө гадна жоохон хойш тавигдах гээд байгаа юм. Тэгэхээр энэ төрийн өмчийн энэ хуулийн этгээдийн засаглалыг 1 өдөр ч гэсэн цаг хугацаа алдалгүйгээр зөв болгох нь бидний нийтлэг эрх ашгаа л гэж бодож байна.

Түрүүн Батнайрамдал гишүүн маань тодорхой хэлж байна. Өнөөдрийн бид нарын зогсоо зайгүй бие биеэ хардаж ч гэдэг юм уу энэ улс төр болоод байгаа сэдвүүд чинь яг л энэ хэдэн төрийн өмчит хуулийн этгээдийг дагаж бий болоод байгаа шүү дээ. Тэгээд энэ хуулийн этгээдийн засаглал талаасаа ингээд харахаар дандаа эрүүл бус Иргэний хуулийнхаа суурь концепц, ойлголтууд байхгүй. Олон улсад ч гэсэн танилцуулаад тэгэхэд ямар статустай хуулийн этгээд юм бэ гэдэг нь ойлгомжгүй ийм л байж байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэний цаана юу вэ гэхээрээ төрийн өмчит үйлдвэрийн газар та бодъё 1 захирал байгаа ХХК ч юм уу хувьцаат компани байлаа гэхэд их хэмжээний хэлцлийг ядаж ТУЗ нь хяналтаараа баталгааж ТУЗ шийдвэрээ гаргаж, хянаж өгдөг байхгүй юу. Гэтэл өнөөдөр төрийн өмчит үйлдвэрийн газар дээр 1 хүн шийдэж байна шүү дээ. Тэгэхээр энийг ингээд цаг алдах ийм зүйл байж болох юм уу? Энэ чинь өөрөө хуулийн этгээдийн засаглал, ард түмний ба өмч болсон энэ төрийн өмчийг чинь үнэгүйдүүлэх маш юу гэдэг юм ойлгомжгүй байдлаар захиран зарцуулж гэдэг юм уу, эдийн засгийн эргэлтэд оруулах асуудал чинь 1 цаг ч гэсэн битгий үргэлжлээсэй л гэж би бодож явж байгаа.

Тэгэхээр энэ асуудал бол нэгээхэн хэсгийг нь шийдчихье. Тэр том хуулиа мэдээж явуулалгүй яах вэ. Би ч гэсэн өөрөө идэвхтэй ажиллаж байгаа. Анхны драфтыг нь босгосон хүн. 21 онд өргөн бариад дахиад 4 жил хойшилсоор байгаад л өнөөдөр хүрчихсэн байхгүй юу. Анх өргөн барьснаасаа хойш 5 жил хэлэлцээгүй шүү дээ. Ингээд л сэдэв болгоод л дараад л хэвтчихдэг.

Тийм учраас энэ удаагийн ажлын хэсэг бол тэгэхгүй байх. Тэгээд энэ асуудлыг ингээд жижиг гэлтгүй цаг хугацаа алдахгүйгээр ингээд шийдээд явъя. Би зүгээр сая л нэг л жишээг л ярилаа. Их хэмжээний жишээ нь хэлцэл гээд энэ хуулийн этгээдүүд дээр байдаг ойлголтыг байгуулах зөвшөөрлийг жишээ нь компани байсан бол ТУЗ-өөрөө дамжуулж өгч байхад төрийн өмчит үйлдвэрийн газар дээр яг ингэнэ ээ гэсэн юм байхгүй. Энэ яг л ойлгомжгүй ийм л зүйл явж байгаа. Тэгэхээр ийм асуудлуудыг ингээд засъя аа л гэсэн ийм зорилт шүү.

С.Цэнгүүн: Мөнхсоёл гишүүн тодруулъя.

Б.Мөнхсоёл: Манай энэ, гацдаг байна шүү дээ. Гишүүн маань өөрөө сайн мэднэ шүү дээ Сайнзориг гишүүн минь. Одоо энэ хууль хэлэлцэгдлээ тэгээд дэмжигдлээ гэж бодоход дараагийн нөгөө том ажлын хэсэг чинь байгаад дөнгөж батлагдсан, магадгүй батлагдлаа гэж бодоход энэ хуулиа дахиад цуцлаад шинээр хэлэлцэх нь байна шүү дээ. Энэ чинь хайран цагийн гарз хайран хүн нөөцийн гарз биш үү? Тухайлбал, тэр зөвлөх үйлчилгээ үзүүлж байгаа компани чинь яадаг юм давхар давхар хөлслөгдөөд явдаг юм уу? Нэг хийсэн юмаа давхар давхар яриад явдаг юм уу? Жоохон ийм логикийн ийм буруу яваад байгаа юм шиг л бодогдоод.../минут дуусав./

С.Цэнгүүн: Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Үүрийнтуяа даргад хариулах боломж олдохгүй байх шиг байна. Бид хэд бол их тийм давхар үйлчилгээ аваад байгаа зүйл ерөөсөө байхгүй. Засгийн газрын Хэрэг эрхлэх газартай хамт ажиллаж байсан Азийн хөгжлийн банкны зөвлөх үйлчилгээ дээр өгч байгаа тэр тайланг нь сонсож байгаа тэр Дүгэржав гуай бол EBRD буюу Засгийн газрын бас тодорхой компаниудын олон нийтийн болгох энэ ажил дээр бэлэн байдлын үнэлгээг хийж ч юм уу нөхцөл байдлыг бас дүгнэж өгсөн.

Дээрээс нь энэ Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн хууль дээр бас зөвлөмж өгсөн ийм л байгууллага юм билээ. Би зүгээр давхар давхар гэрээ гэхээсээ илүүтэйгээр өмнө нь хийсэн ажлыг бол өчигдөр би ирж бас танилцуулаач ээ гэдэг зүйлээр урьсан юм шүү. Яг одоогоор бол ингээд давхар янз бүрийн үйлчилгээг Үүрийнтуяа дарга ч юм уу, би ч юм уу, Номинчимэг бид хэд аваагүй ээ гэдэг зүйлийг бас танд хэлэх нь зөв байх. Энэ бол яах вэ ингэнэ шүү дээ. Яг

үнэндээ хэлэхэд би нөгөө буруу зүйлийг 1 хоног ч үргэлжлүүлэх эрхгүй ээ засаад явах ёстой.

Тэгэхдээ төрийн өмчийн багц хууль маань батлагдлаа гэхэд шууд маргааш үйлчлэхгүй байхгүй юу. Энд бэлтгэл ажил дор хаяж хагас жил хэрэгтэй. Тэгэхээр энэ чинь хагас жил ийм болохгүй юмыг үргэлжлүүлэх.../минут дуусав./

С.Цэнгүүн: Жаргалан гишүүн.

Б.Жаргалан: Өнөөдөр Монгол Улсад бүх л эрх мэдэл, бүх л мөнгө төгрөг, бүх л өмч хөрөнгө төр дээр л овоологдоод байгаа. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас бидэнд гаргаж өгсөн мэдээллээр болохлоор төрийн өмчит компаниуд дээр нийтдээ 65 гаруй их наяд төгрөгийн өмч хөрөнгө байгаа гэсэн мэдээлэл байгаа. Жилдээ бараг 25 их наяд орчим төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллаж байна. Тэгээд энэ төрийн өмчит компаниудын засаглалын асуудал төрийн өмчит компаниуд дээр гарч байгаа алдаа завхралуудын талаар бол маш их ярьдаг. Гэсэн хэр нь асуудал шийдэгддэггүй.

Хууль санаачлагчийн оруулж ирж байгаа асуудлыг бол маш сайн ойлгож байгаа. Төрийн өмчит үйлдвэрийн газар гэдэг Иргэний хуульд ч байхгүй, Компанийн хуульд ч байхгүй ийм ийм сонин нэршлээр бол он удаан жил тодорхой байгууллагууд бол үйл ажиллагаа явуулсан. Тэрийг бол ойлгож байгаа. Гэхдээ гишүүдийн хэлээд байгаа энэ Нийтийн өмчийн тухай хууль болон бусад хуулиудтайгаа хамтраад явах уу гэдэг дээр бол бас эргэлзээ байна.

Би нэг тодорхой хэдэн асуулт асуумаар байна. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын газраас шууд зохицуулж байгаа 99 байгууллагаас 17 төрийн өмчит үйлдвэрийн газар гэсэн байна. Яг ямар компаниуд байна вэ? Энэ компаниудын нөгөө нийтлэг мэдээллүүд байна шүү дээ өмч хөрөнгийн хэмжээ, борлуулалтын орлого, ашиг алдагдал тэр мэдээллүүдээ бас өгмөөр байна. Орон нутгийн түвшинд бол бараг хэдэн мянган компаниуд байгаа шүү дээ. Тэдгээр дотор бас яг энэ төрийн өмчит үйлдвэрийн газар гэдэг ангилалд хэдэн компани харьяалагдаж байгаа вэ? Одоо яг энэ хууль батлагдлаа гэхэд тэр өөрчлөн байгуулагдах яг хэдэн тооны компани байгаа вэ яг ямар ямар компани байна вэ? Бүүр жагсаалт баймаар байна.

Дагаж мөрдөх журам гээд гарсан байна. Тэгэхээр энэ дагаж мөрдөх журмын хүрээнд болохлоор энэ төрийн өмчит үйлдвэрийн газар гэдэг ангилал байхгүй болмогц тухайн компаниудыг бол Засгийн газар, эсвэл орон нутгийн засаг захиргаа нь өөрчлөн байгуулна, эсвэл татан буулгана гэхчхэн байгаа. Энэ дээр надад бол ийм бодит хардлага байна. Өнгөрсөн хугацаанд энэ төрийн өмчит компаниуд дээр байгаа энэ алдагдалтай ажилласан байдал, авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй холбогдсон байдал олон алдаа завхралуудын талаар ярьсан. Тэгмэгц өөрчлөн байгуулах, эсвэл татан буулгах нэрийдлээр энэ бүх баримт нотолгоо нь алга болох вий гэсэн бодит юу гэдэг юм хардлага байна. Энэ асуудлыг бол хууль санаачлагч бас яаж харж байгаа вэ гэж байна.

Дагалдах хуулиар энэ Засгийн газарт эрх олгох тухай 91 оны хууль орж ирсэн. Түрүүн Цэнгүүн гишүүн маань бас хэллээ. Энэ хуулийг бол бие даасан байдлаар бас Улсын Их Хурал хэлэлцэх эсэхийг нь бол шийдвэрлээд ингээд явж байгаа гэж ойлгож байгаа. Тэгээд давхардаад ороод ирчхэж байгаа нь нөхцөлд өнөөдөр бол энэ бараг хэлэлцэхгүй байх нь, хэлэлцэх эсэхийг нь бол дагалдах

дээрээ дэмжихгүй байх нь зөв гэж хараад байна. Тэгээд эхний ээлжид саяын хэдэн асуултад яг тодорхой хариулт өгнө үү.

Б.Жаргалан: Ажлын хэсгийн 1 дүгээр микрофон.

Ц.Баяр-Эрдэнэ: Жаргалан гишүүний асуултад хариулъя. Ер нь бол орон нутгийн хэмжээнд бол 105 төрийн өмчит үйлдвэрийн газар байгаа. Нийслэлд бол 40 гаруй хамгийн их олон нь Өмнөговь аймагт. Эдгээр байгууллагууд бол их олон чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Яг орон нутгийн түвшинд 500-гаад хуулийн этгээд аж ахуйн үйл ажиллагаа явуулж байгаагаас дийлэнх нь буюу 305 нь үйлдвэрийн газар хэлбэртэй гэдгийг онцолж хэлье.

Ер нь бол Төрийн болон орон нутгийн өмчийн хуульд үйлдвэрийн газрыг 2 хэлбэрээр байгуулж байгаа. Нэг нь бол улсын төсөвт үйлдвэрийн газар, нөгөөдөх нь аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар. Их, дээд байгууллагууд бол бол улсын төсөвт үйлдвэрийн газарт орж байгаа. Яамны харьяа төсвийн санхүүжилтийн эх үүсвэртэй ийм байгууллагуудыг бол улсын төсөвт үйлдвэрийн газар гэж нэрлэдэг. Эдгээр газрууд бол 40 гаруй ийм байгууллага байгаа.

Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар бол өнөөдөр, яг өнөөдрийн байдлаар бол 17 ийм байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Би яг бүрчлэн нэршилээр нь ингээд хэлчихье. “Эрдэнэт” үйлдвэр, “Эрдэнэс критикал минералс” буюу Монрос, Автотээврийн үндэсний төв, Зам, тээврийн хөгжлийн төв, Барилгын хөгжлийн төв, Геологийн судалгаа-шинжилгээний төв, Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар, Монгол кино нэгтгэл, Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв, Мэдээллийн технологийн үндэсний парк, Засгийн газрын автобааз, Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн, Замын-Үүдийн дулааны станц, Монгол Кувейтийн Уур амьсгалын өөрчлөлт хамтын ажиллагааны судалгааны төв. Энэ дээр Монгол, Кувейт Аялал жуулчлалын хөгжлийн төв хоёрыг нийлүүлээд өөрчлөн зохион байгуулчихсан байгаа юм. Ер нь бол өнгөрсөн хугацаанд 4 орчим үйлдвэрийн газрыг бол өөрчлөн байгуулж нэгтгэж нийлүүлсэн ийм үр дүнтэй байгаа.

Ер нь бол энэ аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрууд маань бол төртэй гэрээлэх замаар төрийн зарим нэг ажил, үйлчилгээг л төрийн нэрийн өмнөөс хийж байгаа ийм л байгууллагууд байгаа. Тухайлбал, Авто тээврийн үндэсний төв бол хөдөлгөөний зохицуулалт тэгээд нөгөө номер дугаар, энэ машинуудын нөгөө гэрчилгээ хэвлэхээс өгсүүлээд ийм аж ахуйн шинжтэй үйл ажиллагаануудыг хийдэг.

96 онд батлагдахдаа энэ бол төрийн өмчит үйлдвэрийн газрын статусыг энэ Төрийн болон орон нутгийн өмчийн хуульд их тодорхой зоогоод өгчихсөн ийм л зүйл байгаа.

С.Цэнгүүн: Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Жаргалан гишүүний асуултад хариулъя. Аливаа хуулийн этгээдийг татан буулгах байдаг юм уу, зорилгодоо хүрлээ гээд татан буулгаж болно, эсвэл дампуурал төлбөрийн чадваргүй болоод татан буулгаж болно. Энэ нөхцөл байдал чинь ажил хүлээлцэх, архивд шилжүүлэх гээд тодорхой процесстой. Хэдүүлээ их ийм юм алга болчихно энэ тэр гэдэг юм чинь байхгүй шүү дээ. Энэ бүх зүйлүүд чинь татвартай харьцаад явж байгаа. Нийгмийн даатгалтай харьцаад явж байгаа. Харилцагч байгууллагууд шилэн дансанд бүх зүйлүүд

ингээд суурилад явж байгаа. Тэгэхээр би бол ийм зүйл бол гарахгүй байх аа гэж бодож байна.

Аль болохоор зөв засаглал руугаа явдаг юм байхгүй бол энийг чинь хууль хэрэгжүүлэх доор нь тэр чинь сонгож хэрэглээд байна шүү дээ. Ядаж энийг нь хаагаад өгье өө л гэж байгаа юм. Тэгээд дараа нь тэр төрийн өмчийн том реформ явахаар бүүр цэгцрээд явна. Тэгэхгүй өнөөдөр ингээд Эрдэнэтээс эхлээд дөнгөн данган үйл ажиллагаа явуулдаг ч байгууллагууд байна. Ийм хэлбэр рүү орчихоор чинь энэ чинь яаж бид нар нөгөө Үндэсний баялгийн сан, Үндсэн хуулийн үзэл баримтлалын дагуу эргээд энийг олон нийтийн болгох зорилт, тэгээд энэ хяналтын асуудал энийг дагасан эрсдэлийг дараа нь.../минут дуусав./

С.Цэнгүүн: Жаргалан гишүүн тодруулъя.

Б.Жаргалан: Энэ хуулийн төслийн үйлчлэлд хамаарах саяын уншиж танилцуулсан компаниудынхаа жагсаалтыг бичгээр хүргүүлээд өгөөч. Мэдээж хэрэг төрийн өмчит компаниудын засаглалыг сайжруулъя, одоо байгаа хууль тогтоомжтой нийцүүлье гэдэг үндсэн зорилготой бол санал нэг байгаа. Гэхдээ гарч болзошгүй асуудлуудыг бид нар бүгдээрээ маш нарийн тооцоолж байж бас явах ёстой.

Тухайлах юм бол “Эрдэнэт” үйлдвэр. “Эрдэнэт” үйлдвэрийн тухайлсан кэйс дээр энэ өөрчлөн байгуулах процессыг ер нь хууль санаачлагч юу гэж харсан юм бэ? Ямар арга хэлбэрээр өөрчлөн байгуулагдах юм? Тэгээд үүнээс гарч болзошгүй ямар эрсдэлүүд байгаа юм гэдгээ бас яг тодорхой кэйс дээр тайлбарлаад өгөөч.

С.Цэнгүүн: Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Энийг Засгийн газар хэрэгжүүлнэ. Тэгэхээр “Эрдэнэт” өөрөө өмнө нь ч гэсэн ХХК л байсан. Мэдээж энд Эрдэнэтийн 49 хувийг ОХУ-ын талаас шилжүүлж авах процесстой холбоотой хуулийн маргаан гараад явж байгаа. Энэнтэй ч холбоотой зарим энэ хуулийн этгээдийн хэлбэрийн өөрчлөлт ч явсан байхыг үгүйсгэхгүй. Тэгэхдээ надад байгаа зүгээр сүүлийн үед сонссон мэдээллээр энэ хэлэлцээрүүдээ үргэлжлүүлээд дуусах юм байна гэж ойлгосон. Энэ юу гэдэг юм нэгэнт энийг төрд бүгд бүхэлд нь 100 хувь авна гэдгээ шийдчихсэн шүү дээ.

Харин тэр компанийн оруулсан гэдэг юм уу тэр тооцоо нийлэх асуудлаа шийдээд явах ёстой. Энэ Эрдэнэтийг харин хуулийн этгээдийн засаглалынх нь хувьд яг зөв байлгах, нээлттэй байлгах, сонгон шалгаруулахдаа мэргэжлийн баг удирдах илүү их үр өгөөж нь Үндэсний баялгийн сангаар байдаг юм уу төсвөөрөө дамжуулаад төсвийн бодлоготой уялдуулаад явах заалт руу л бид нар чиглүүлэх ёстой.

Тэгээд яах вэ зүгээр нэг зүйлийг бас эцэст нь хэлмээр байгаа юм. Маш олон жил энэ төрийн өмчийн реформыг хийнэ ээ л гэж байсан. Тэгээд би яах вэ өөрөө .../минут дуусав./

С.Цэнгүүн: Сайнзориг гишүүнд 1 минут.

П.Сайнзориг: Итгэл бол байна. Тэгэхдээ аливаа бас хуулийг батлуулах цаг хугацаа, товыг бас тэр энэ нь төдийд гэж бас хэлэх бололцоогүй байгаа учраас л ийм арга хэмжээг наад захын арга хэмжээг авъя аа л гэж байгаа юм.

Тэгэхээр энэ бол өөрөөр Нийтийн өмчийн хуулийн маш том асуудлуудыг бид нар ойлголцолд консенсуст хүрэх ёстой. Төрийн болон орон нутгийн өмчийн хууль дээр ч гэсэн консенсуст хүрэх маш олон асуудлууд байгаа. Тэгэхээр энэ хуулиудыг батлахын төлөө явна. Энэ хуулийг би хэлэлцүүлж байгаагаараа энэ хуулийг зогсоох гээд байгаа зүйл байхгүй. Аль болохоор яваасай гэж бодож байгаа байхгүй юу. Тэгээд тодорхой хэмжээнд энд бас түрүүн Батнайрамдал гишүүн хэлж байна олон жил ярьсан мөртөө чадаагүй байгаа. Тэгэхдээ энэ парламент чадах байх гэсэн итгэл байгаа боловч энэ зарим асуудлуудыг өнөө, маргаашийн ч гэсэн өөрчлөлтийг нь хийгээд явах ёстой л гэсэн ийм байдлаар бас хуулийн төслийг бас харж хийж хэлэлцүүлж байгаа шүү гэдэг зүйлийг бас хэлмээр байна аа.

С.Цэнгүүн: Мандхай гишүүн.

М.Мандхай: Төрийн өмчит үйлдвэрийн газрыг ерөнхийдөө энэ аж ахуйн тооцоот газрыг төрийн өмчийн компани гэдэг хэлбэр рүү ер нь шилжүүлж байгаа. Ингэснээрээ ер нь засаглал ил тод байдлыг илүү нээлттэй болгож байна аа гэсэн ийм утга агуулгатай, үзэл баримтлалтай хуулийн төсөл юм байна гэж харсан. Гэхдээ бид нар энэ дээр хууль дээр нэр хэлбэр төдий биш цаад амин сүнснийг сайжруулахгүй болохоор одоо яг ямар асуудал үүсэж байна гэхлээр 105 төрийн өмчит компанийн бараг 40 нь гэхэд зөвхөн Засгийн газрын харьяанд байдаг. Энэ нь юу хэлж байна гэхлээр үндсэндээ бол Засгийн газрын Хэрэг эрхлэх газар өөрөө бодлого боловсруулж Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавьдаг институц өөрөө корпорац болтлоо өргөжсөн байгаад байгаа юм.

Тэгэхлээр энэ ер нь ямар асуудал вэ гэхлээр энэ зүгээр компанийн энэ хэлбэрийг өөрчилснөөрөө энэ углуургаар энэ асуудал ер нь шийдэгдээд байгаа юм биш. Тэгэхээр энэ нэгдүгээрт би ийм юм асуумаар байгаа юм. Энэ компани ХХК болох гээд байна уу, эсвэл нээлттэй, хаалттай энэ ХК-ийн хэлбэр рүү нэгдүгээрт шилжүүлэх гээд байгаа юм уу гэдгийг тодорхой болгож өгөөч ээ.

Хоёрдугаарт бид нар энэ төрийн компаниуд төрийн өмчит энэ компаниуд дээр хэн удирдаж байгаа, хэн хариуцлага хүлээж байгаа гэдэг механизм улс төрийн нөлөө өөрчилж чадахгүй л бол бид нар ямар ч хэлбэр рүү шилжээд энэ нөгөө л угжирсан асуудал бол ерөөсөө хэвээрээ. Тэгэхээр үндсэндээ бол компанийн зан төлөв бол өөрчлөгдөхгүй зүгээр л энэ зөвхөн мөнгөний эх үүсвэр л нааш цаашаа солигдож байгаа асуудал ерөнхийдөө болох юм. Тэгэхээр би нэгдүгээрт энэ компанийн хэлбэрийг асууя.

Хоёрдугаарт, нийтийн үйлчилгээний байгууллага гэж байгаа юм. Үндсэндээ бол энэ ашгийн бус маш олон байгууллагууд байна шүү дээ сая бас заримаас нь дурдлаа Автотээврийн үндэсний төв, Дипломат байгууллагын үйлчилгээний газар ч гэдэг юм уу энэ Барилгын хөгжлийн төв зэрэг энэ нийтийн үйлчилгээний компаниуд байна, байгууллагууд байна. Эд нарыг одоо ингээд компанийн хэлбэр рүү шилжүүлэхээр хэрэглэгчдэд үзүүлж байгаа үйлчилгээний төлбөр нэмэгдэнэ. Тэгэхлээр энэнтэй холбоотойгоор үүсэх зардал энэ чинь нөгөө ашгийн бус байгууллага учраас дараа нь компанийн өөрийнх нь баланс дээр далд ийм алдагдал хэлбэр үүсэх эрсдэл харагдаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг яаж зохицуулж байгаа юм? Энэ дээр тодорхой хариулт өгөөч. Тэгэхээр энэ ашгийн

төлөө, ашгийн төлөө бус, энэ ашгийн бус чиг үүрэгтэй нэгжид яг ийм ижил ийм загвар хэрэгжих гээд байгаа юм уу гэдэг нь бас яг хууль дээр бол тодорхой харагдахгүй байгаад байгаа юм.

Гуравд нь зардлын тооцоон дээр огт зардал үүсгэхгүй гэдэг ийм дүгнэлт гаргачихсан байгаад байгаа юм. Би бол тэгж бодохгүй байгаад байгаа юм. Яагаад гэхлээр энэ компанийн хэлбэр өөрөө солигдоод ирэхээр мэдээж энэ чинь тодорхой хэмжээний компани дээр үнэлгээ хийгдэнэ, аудит хийгдэнэ. Дүрмийн бас шинэчлэлүүд явагдах байх. Улсын бүртгэл дээр тодорхой хэмжээний бүртгэлийн ажлууд хийгдэнэ, ажилтны шилжилт хөдөлгөөн гарна гээд, өр төлбөр, хөрөнгийн асуудал гээд энэ чинь маш.../минут дуусав./

С.Цэнгүүн: Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: ХХК болох уу хувьцаат компани болох уу? Энэ Засгийн газрын яг хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх. Тэгэхдээ ер нь шууд ХК болох ямар ч боломжгүй. Энэ компанийг ядаж наад захын засаглалын зөв хэлбэрт оруулж хязгаарлагдмал хариуцлагатай компани болгож байж дараагийн алхмуудыг хийнэ.

Жишээ нь, “Эрдэнэт” төрийн өмчит үйлдвэрийн газар. Энийг бараг 90-ээд оны дундуураас эхлээд л иргэдэд бас тодорхой хувьцааг нь эзэмшүүлнэ ээ гэдэг ярьсан. Одоо өмч хувьчилж болохгүй эд хөрөнгийн жагсаалтад хэд хэдэн удаа дурдагдаж сүүлд ингээд хасагдсан л байж байгаа юм. Тэгэхээр нэгэнт энэ “Эрдэнэт” үйлдвэр жишээ нь Монгол Улсын төрийн өмчид 100 хувь хүрээд ирчихсэн байж байхад энэний хяналтыг сайжрах л хүрээнд орон нутгийн иргэд энэ Монгол Улсын иргэдэд бас тодорхой хувьцааг нь өгөх ёстой шүү дээ. Тэгэхээр энэ зүйлүүдийг өнөөдөр яг ийм хуулийн этгээдийн хэлбэрээр хаагаад байгаад байгаа нь буруу л гэж харж байгаа юм. Тэгээд би зүгээр 1 л жишээг аваад ярилаа.

Хоёрдугаарт, энэ алдагдлын асуудал төрийн өмчит үйлдвэрийн газар байгаа нь алдагдалгүй ажиллаж байгаа, ХХК ч юм уу Х болохоор алдаг гараад тэрийг далд хэлбэрт ор гэж тийм юм байхгүй шүү дээ Мандхай гишүүн ээ. Одоо ч энэ бүх нягтлан бодох бүртгэлийнхээ явцад энэ нийгэмд юу гэдэг юм “Public Service Obligation” буюу нийтийн үйлчилгээний салбаруудыг зарим аж ахуйн нэгжүүд нь хийгээд л явж байгаа. Энэ татаасаа аваад явж байгаа.

Тэгэхээр энэ зүйлүүдийг юу гэдэг юм зөв зохицуулалтад орох. Ядаж 1 хүн эрсдэлийг ганцаараа шийдээд байх биш энэ шийдэх ёстой бизнес төлөвлөгөөг нь баталдаг, үр дүнтэй ажиллах, үр ашигтай ажиллах, эсвэл ашигтай ажиллахын төлөө зорих ёстой байхгүй юу. Өнөөдөр чинь ингээд яах гэж байгаа нь мэдэгдэхгүй ингээд хувийн өмч ч болчихсон ч юм шиг ийм төрийн өмчит үйлдвэрийн газруудыг ингээд байлгаад байж болохгүй шүү дээ. Тэгэхээр би бол энэ дээр ямар нэгэн байдлаар ХХК ч юм уу ХК болсны дараа алдагдлыг яах вэ үнэ тариф өсөх юм шүү тийм зүйл байхгүй. Энэ бүх зүйлүүд чинь одоо явж байгаа зүйлүүд ээ.

Зардал мөнгөний хувьд бол энэ Засгийн газрын зүгээр энэ бол тодорхой зүгээр хуулийн хэрэгжүүлэхтэй холбоотой юу гэдэг юм тийм нүсэр зардлууд бол байхгүй. Энэ зүгээр зарим нь бол ихэнх нь хувьцаат компани байсан шүү дээ. Энийг л зүгээр улсын бүртгэл дээр шийдвэр өөрчлөх замаараа л төрийн өмчит үйлдвэрийн газар болгочоод байгаа. Дээрээс нь 16 онд санаж байна Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн хууль батлаад аваачаад үйл ажиллагааны

чиглэлүүдийг хуулийн этгээдийн хэлбэр гэж тооцоод бүртгэлд бүртгүүлсэн маш олон юм гарсан байхгүй юу. Соёлын байгууллага, боловсролын байгууллага, эрүүл мэндийн байгууллага гээд. Энэ хуулийн этгээдийн засаглал талаасаа ойлгомжгүй болоод сүүлдээ энэ чинь баахан өмчийн маргаан энэ нөгөө их хэмжээний хэлцэл гэдэг шиг зарим нь ТУЗ-өөрөө орж зөвшөөрөл авч хийдэг хэлцлүүдийг чинь дан ганц захирлууд нь шийдээд ийм олон зүйлүүд үүссэн юм аа. Тэгээд энийг л ингээд цаашдаа гаргуулахгүй байх нь энэ төрийн өмчийг үнэгүйдүүлэхгүй байх, эрсдэлд оруулахгүй байх алхам аа л гэж бид нар харж байгаа юм.

С.Цэнгүүн: Мандхай гишүүн тодруулъя.

М.Мандхай: Тэгэхээр одоогийн байгаа хэлбэр өөрөө алдагдалтай ажиллаад тэгээд тэр нь бол ил тод алдагдал нь ингээд ил тод гарч байгаа гэж байгаа. Тэгэхдээ энэ хэлбэр өөрчлөгдөхөөр ер нь бол энэ Компанийн тухай хууль энэ бусад яг энэ үндсэн энэ үйл ажиллагаа нь өөрөө яг ямар хуулиар тэгвэл зохицуулагдах юм бэ гэж би тодруулж асуумаар байна. Яагаад гэхлээр хэрэв Компанийн тухай хуулиар бид энэ байгууллагууд зохицуулагдаад явах юм бол энэ дахиад өөр асуудал руу болоод явчхаж байгаа байхгүй юу. Цалин хөлсний урамшуулал, нэр дэвшүүлэх, тэгээд хувьцаат компани дээр болоод ирэх юм бол тэр байтугай бүр жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг яаж хамгаалах, ТУЗ-ийг яаж байгуулах, гүйцэтгэх засаглалыг яах вэ гээд ингээд чинь бүр дахиад өшөө нарийн ийм зохицуулалттай асуудал болоод явчхаж байгаа юм.

Тэгэхлээр бид нар зүгээр хэлбэрийг өөрчилъе өө гээд дахиад энэ чинь бусад яг гол ямар хуулиар энэ нь өөрөө үйл ажиллагаа зохицуулагдах юм, яаж явах вэ гэдгийг бас нарийн энэ хуульдаа зааж өгч тус.../минут дуусав./

С.Цэнгүүн: Мандхай гишүүнд 1 минут.

М.Мандхай: Тэгэхлээр энэ яг гол хэлээд байгаа санаа нь өөрөө бид нар энэ одоо байгаа байгууллагуудынхаа институцийн суурь асуудлыг яагаад алдагдалтай ажилласан юм бэ? Энэ нь улс төрийн нөлөөнөөс болоод энэ томилгоонууд нь шударга бус яг бодитой чадвартай хүмүүсийг авч ажиллуулаад ингээд нөгөө тайлан баланст нь нөлөөлдөггүй ийм хэлбэрээр ажиллах нөхцөлийг нь хангаж өгөөгүй юм биш биз дээ? Яг яагаад энэ алдагдалтай ажиллаж байгаа вэ гэдэг дээр бодитой үнэлэлт, дүгнэлт хийж явахгүй бол зүгээр хуульд бид нар өө энэ ийм учраас энийг компани болгох ёстой юм аа гээд ингээд явчихаар нөгөө ямар ч зүгээр л ийм хэлбэр төдий өөрчлөлт болж харагдаад байгаа байхгүй юу.

Тэгэхлээр энэ дээр би бол яаран дааран энэ хууль дээр ингээд хэлбэр төдий өөрчлөлт хийчих вий гэдэг дээр бол санаа зовж байна. Дахиад нөгөө хэлбэр бодитой яг өөрчлөлт гарахгүй зүгээр л ингээд цаана нь.../минут дуусав./

С.Цэнгүүн: Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Гишүүндээ бас баярлалаа. Тэгээд энэ тийм хэлбэрийн өөрчлөлт биш л дээ Мандхай гишүүнээ. Цэвэр агуулга өөрчлөгдөнө. Төрийн өмчит үйлдвэрийн газар гээд 1 хүн удирдах уу компанийн хэлбэрт оруулж энэ тодорхой бүтцүүд нь ажиллаж, хяналтаа тавьж, үр ашгийг дээшлүүлэх үү? Энийг цаашдаа олон нийтийн болгох, эсвэл энэ төсвийн бодлогодоо ноогдол ашиг хүртээдэг байх зарчим руу шилжих үү? Төрийн өмчит үйлдвэрийн газар чинь яг ноогдол ашиг өгнө

гэсэн юм байхгүй шүү дээ. Энэ зүгээр ингээд тодорхой хэмжээний удирдамж гэдэг юм уу явж ирж байгаа л ийм практикаар явж байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ бүтэц рүү шилжиж байж бид нар дараа нь энэ компанийн чинь алдагдалгүй ажилла, ашигтай ажилла, төсвийн бодлоготойгоо уялдуулж төсөвт ноогдол ашиг өг. Магадгүй зарим компаниудыг иргэд олон нийтэд санал болгож болно шүү дээ. Энэ хэлбэрийн өөрчлөлт биш шүү. Тэгээд би зүгээр өчигдөр бас энэ хэлэлцүүлгийн явцад болсон тэр New Zealand улсаас ирсэн зөвлөхийн зүгээр жишээг ярья л даа. Тэнд бол яах вэ Меркури энерги.../минут дуусав./

С.Цэнгүүн: Гүйцээж хариулъя.

П.Сайнзориг: 2 компанийг зүгээр New Zealand-д хувьчилсан юм байна лээ. Хувьчлаад 50 хувийг олон нийтэд санал болгосон. Тэр компанийн ашиг даруй жилийн дотор 2 дахин өссөн. Төр 100 хувь байхаасаа илүү. Би тэгэхээр энд нөгөө өмч хувьчлалыг ч юм уу олон нийтийг болгох гээд байгаадаа биш. Энэ өөрөө тэр төрийн өмчит үйлдвэрийн газрыг удирдаж байгаа хүндээ ч хэцүү байхгүй юу. Ганцаараа дараа нь энэ бүх эрсдэлүүдийг хүлээж хариуцлага хүлээх юм уу эсвэл энэ бизнес төлөвлөгөөгөө баталдаг бүтэцтэй тэн дээрээ хяналтаа тавьдаг дуу хоолойтой. Энийгээ цаг хугацаанд нь бас асуудлуудыг ярьдаг, тайлагнадаг, одоогийн явж байгаа Компанийн хууль болон Төрийн өмчийн хуулиар явах юм уу гэдэг л асуудал байхгүй юу.

Наад төрийн өмчит үйлдвэрийн газар гэдэг чинь бүр ойлгомжгүй байгаа шүү дээ. Ерөөсөө цөөн хэдэн заалт байгаа. Тэгээд энэ өөрөө эргээд нөгөө социализмын үеийн зохицуулалтын үлдэгдэл санаа явж байгаа учраас өнөөдрийн энэ бизнес, эдийн засгийн орчинд чинь тохирохгүй байгаад байхгүй юу. Тэгэхээр би бас таныг хэлбэрийн өөрчлөлт хийх гээд байна гэхээсээ илүүтэй.../минут дуусав./

С.Цэнгүүн: Гишүүд асуулт асууж дууслаа.

Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү.

Мандхай гишүүнээр. Уянгахишиг гишүүнээр тасаллаа. Үүрийнтуяа гишүүний микрофоныг.

Д.Үүрийнтуяа: Сайнзориг гишүүний оруулж ирж байгаа хуулийн төслийн агуулга, хэрэгцээ шаардлагыг бол ойлгож байгаа. Үнэхээр өөрчлөх шаардлагатай юу? Шаардлагатай бас богино хугацаанд өөрчлөгдчихөөсэй, өөрчлөлт орчхоосой гэдгийг бас ойлгож байна.

Гэхдээ бид бас зарчмын асуудал барихгүй бол болохгүй байна. Яригдсан асуудал дээр дэс дарааллаар нь бас хариултауд байр сууриа илэрхийлээд явъя гэж бодож байна.

Нэгдүгээрт, энэ Цэнгүүн гишүүний санаачилсан хууль тэр хүчингүй болгох тухай 1991 оны Засгийн газарт чиглэл өгөх тухай хууль бол яг энэ асуудлыг таныг нэгтгээч ээ гэж бол хандаагүй юм. Сайнзориг гишүүнийг энэ хуулиа татчих юм бол Төрийн болон орон нутгийн өмчийн хуульд оруулж байгаа энэ өөрчлөлтөө татчих юм бол дагаж орж ирсэн хууль нь тэртээ тэргүй хүчингүй болоод шийдэгдээд

явчих юм байна. Тийм учраас дагасан хуульд бол асуудал үүсэхгүй юм байна аа гэдэг агуулгаар хэлж байгаа.

Хоёрдугаарт, тэр өмч хувьчлалын асуудал дээр бол сая Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар байр сууриа бүрэн илэрхийллээ. Бид Улсын Их Хурлаар өмч хувьчлалын үндсэн чиглэлийг баталсан болохоос өмч хувьчлалын жагсаалтыг батлах тухай асуудлыг хэлэлцэх эсэхийг нь дэмжээгүй л дээ. Тэгэхээр энэ бол үндсэн чиглэлийн асуудлыг хэлэлцэх эсэх нь дэмжигдээд явж байгаа гэдэг дээр зөв ойлголттой, хаа хаанаа нэг ойлголттой байх нь зөв болов уу гэж бодож байгаа юм.

Одоо яг энэ хуулийн төслийн хувьд бол би бас ер нь энэ асуудлаа нэгтгээд явсан нь зүйтэй л гэдэг байр суурьтай байгаа. Хэрвээ яг энэ асуудал чухал байна аа гэж үзвэл одоо нийтийн өмч нэртэйгээр шинэчилсэн найруулга явж байгаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд шинэчилсэн найруулга орж байгаа буюу 50 хувиас дээш өөрчлөгдөж байгаа. Сайнзориг гишүүний өнөөдрийн гаргаж ирж байгаа энэ асуудал бол чухал.

Гэхдээ энэ 50 хувьд орж байгаа өөрчлөлтийн ерөөсөө л нэг хэсэг. Цаана нь маш олон асуудлууд мөн яаралтай өөрчлөх шаардлагатай зүйлс бий. Энийг яаралтай байна аа гээд нэг нэгээр нь оруулж ирээд байвал энэ чинь өөрөө утгаа алдана.

Тийм учраас нэгэнт энэ хуулийн шинэчилсэн найруулга хэлэлцэгдээд явж байгаа, ажлын хэсэг гарчихсан, анхны хэлэлцүүлэгт бэлтгэж байгаа ийм нөхцөл байдалд бол энэ асуудлыг нэгтгээд явах нь зүйтэй.

Харин манай энэ дэмжиж үг хэлж байгаа гишүүд бол энэ хуулийн Төрийн болон орон нутгийн өмчит компанийн засаглал ил тод бүтээмжийг сайжруулах хууль, мөн Нийтийн өмчийн тухай хууль энэ 2 хуулийн анхны хэлэлцүүлгийг бол маш яаралтай бас хийхэд дэмжлэг үзүүлж, энэ хуулийн төслийг дэмжиж ажиллаасай гэж ингэж хүсэж байгаа юм. Тэгэхээр энэ асуудлаа нэгтгээд явах нь зүйтэй болов уу. Тийм учраас миний хувьд бол яг энэ төсөл дээр дэмжихгүй байр суурь илэрхийлж байна.

С.Цэнгүүн: Уянгахишиг гишүүн.

Г.Уянгахишиг: Миний хувьд бол бас яг нөгөө том ажлын хэсэгт бол байгаа. Тэгэхдээ Сайнзориг гишүүн болон бусад гишүүдийн энэ өргөн барьсан энэ хуулийг бол ерөнхийдөө дэмжих, хэлэлцэх эсэхийг нь бол дэмжих саналтай байгаа юм.

Яагаад гэхээр нэгэнт хэлэлцээд эхлээд хэлэлцэхийг дэмжээд хэлэлцээд явж байхад 2 хуулийн ажлын хэсгийг жишээлбэл нэгтгэж ер нь бол зарчмын хувьд болно. Зүгээр одоо энийг хэлэлцэх эсэхийг нь дэмжихгүй байлаа гээд тийм, тэгээд хэлэлцэх эсэхийг нь дэмжихгүй ингээд буцаачихаар нөгөө хууль маань явахгүй байгаад байвал яг энэ зохицуулалт маань дутуу хэвээрээ байгаад байх байхгүй юу.

Тэгэхээр би энийг ямар ч байсан хэлэлцэх эсэх нь дэмжигдээд, хэлэлцэгдээд, ажлын хэсэг байгуулагдаад ингээд явж байхад нөгөө ажлын хэсэг маань үйл ажиллагаа нь яг адилхан хурдаар явж чадвал нэгтгэгдэх асуудал бол байж болно.

Яг энэ хуулийн төслийн хамгийн чухал хэсэг юу байна вэ гэхээр өнөөдөр бид нар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль дээрээс харвал тэр аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар болон төсвөөс санхүүждэг үйлдвэрийн газар гээд 2 тусдаа хуулийн этгээдийн төрөл гаргачихсан.

Тэгэнгүүт тэр нь өөрөө заавал компани байх албагүй болчихоод байгаа юм. Тэгээд компани биш байхаар нөгөө бид нарын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд оруулсан засаглалын буюу нөгөө шилэн данс гээд ингээд засаглалын дэвшилтэт заалтууд чинь тэр үйлдвэрийн газар гэдэг хуулийн этгээдэд хамаарахгүй болчихоод байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ үйлдвэрийн газар гэдэг энэ бол Компанийн тухай хуульд ч гэсэн оруулаад энэ үйлдвэрийн газрыг хувьчлаад ерөнхийдөө компанийн хуульд шилжүүлнэ ээ, хэлбэрт шилжүүлнэ ээ гэдэг ажиллагаа анхнаасаа тооцоологдож хийгдэж явж байсан зүйл маань энэ олон жилийн хугацаанд дуусаагүй байгаад байгаа юм. Тэгэхээр Сайнзориг гишүүний өргөн барьсан хуулийн дагалдах хууль дээр, хууль болон Их Хурлын тогтоолын төсөл дээр байна л даа. Өөрөөр хэлбэл, яг энэ үйл ажиллагааг хурд асгах буюу тодорхой хугацаа өгөх.

Тэгэхээр энийг давхар явж байхад бол нэг их болохгүй юм байхгүй харагдаад байгаа байхгүй юу. Тийм учраас би бол хэлэлцэх эсэхийг нь дэмжээд цаашдаа нөгөө Нийтийн өмчийн тухай хууль болон Төрийн өмчит компанийн тухай хууль нөгөө урт нэртэй хууль байгаа тийм ээ тэр хоёрыгоо явуулаад тэгээд яг тэр дундаа энэ асуудлыг тэр зохицуулах гээд байгаа асуудал тэр дотроо шингэж байна уу, шингэчихгүй байна уу энэ хоёрыгоо бас хамтад нь яриад ер нь аль аль асуудлаа шийдээд явсан нь зүйтэй болов уу л гэж бодож байна. Тэгэхээр энийг хэлэлцэх эсэхийг бол дэмжсэн санал хэлж байна гэсэн үг.

С.Цэнгүүн: Мандхай гишүүн.

М.Мандхай: Энэ хуулийг бол яах вэ ер нь бол явуулах нь зүйтэй. Компанийн хэлбэр рүү оруулаад цаашаагаа асуудал нь юу гэхлээр компанийн хэлбэрт оруулахдаа гол нь нөгөө хуучин энэ хариуцлагын зохицуулалтыг нь хасаад шинэ хариуцлагын механизмыг нь тодорхой суулгаж өгөөгүй учраас би ингээд шүүмжтэй хандаж байгаа юм шүү.

Яагаад гэхлээр энэ 55 дугаар зүйл дээр энэ нөгөө компани болгох эхний алхам нь өөрөө тодорхой болж байгаа мөртөө олон нийтийн болгоод хувьцаат компани болгох, цаашаагаа энэ төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоох гээд энэ эрх зүйн зохицуулалт нь өөрөө энд нөгөө 55 дугаар зүйлийг чинь аваад хаячхаж байгаа байхгүй юу. Тэгэхээр энийгээ тодорхой тусгамаар байна.

Хоёрдугаарт, Үүрийнтуяа гишүүний яриад байгаа хууль бол бараг дараагийн процессын хууль байж болохуйц харагдаад байгаа юм. Энэ нь өөрөө компанийн хэлбэрийг шилжүүлчхээд бүтээмжийг нь сайжруулах гэдэг асуудал бол дараагийн бараг процессын хууль байж болохоор харагдаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр би бол зүгээр хэлээд байгаа санаа нь хэтэрхий хэлбэр төдий болчих вий. Тийм учраас энэтэй холбоотой энэ өөрөө цаашаагаа засаглалын хувьд сайжраад олон нийтэд нээлттэй болох, компанийн нөгөө суурь институцийн

асуудлыг өөрөө зөв болох дээр нь энэ компани гэдэг хэлбэр рүү шилжээд явахдаа нарийн өшөө сайн тусгаж өгөөч ээ гэдгийг хэлэх гэж байгаа юм.

Тэгэхгүй бол ингээд Орон нутгийн өмчийн тухай хуулийн 15-аас ингээд 20 дугаар зүйл хүртэл нь бүгдийг нь тийм харин тэгэхээр Компанийн хуулиар зохицуулагдахаар, үгүй тэгэхээр харин төрийн оролцоотой болох юм бол яг хэн хариуцлага хүлээх юм? Хэн удирдах гэдэг удирдлагын тэр засаглалын механизм чинь өөрөө тодорхой болохгүй болохоор шууд Компанийн хуулиар зохицуулагдахаар наадах чинь учир дутагдалтай болчихоод байгаа юм аа. Тийм, тэгэхлээр миний санаа хэлэх гээд байгаа зүйл нь өөрөө энэ компани болгох, болох нэг алхам хийж байгаа ч гэсэн дараагийнхаа тэр нөгөө нээлттэй болгох тэр механизмуудыг илүү бүдгэрүүлэхгүй илүү энэ хуульдаа нарийвчилж тодорхой оруулж өгвөл зүгээр юм байна аа гэсэн ийм саналтай байна.

С.Цэнгүүн: Гишүүд танхимд цуглана уу? Санал хураалт явуулна.

Би Улсын Их Хурлын гишүүнийхээ хувиар бас дэмжсэн, дэмжээгүй байр сууриа бас илэрхийлье. Тэгэхээр БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хууль бол өргөн баригдаад тэгээд хэлэлцэх эсэх нь бол чуулганы нэгдсэн хуралдаанаар ороод дэмжигдсэн байгаа. Үүнтэй холбоотойгоор энэ төрийн өмчит компаниудын тухай маш чухал хууль хэлэлцэгдээд явна. Үндсэндээ Сайнзориг гишүүний өргөн барьсан хуулиас хамт өргөн мэдүүлсэн хууль дотор байгаа. Тэр утгаараа бол хамт өргөн мэдүүлсэн хууль дээр нь, санал дээр бол дэмжихгүйгээр яваад харин Төрийн өмчит компанийн тухай хууль нь тусдаа явбал дээр юм болов уу гэсэн байр суурийг би бол харж байна.

Гишүүдийг танхимд урья. Санал хураалт явуулна. 2 санал хураалт байгаа. 3 санал хураалт. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Гишүүд хуруугаа уншуулаарай. Санал хураалтад бэлтгэе. Мандхай гишүүн 3 санал хураалт байна.

Эхний санал хураалт. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

2 дахь санал хураалт. Санал хураалтын дүн санал хураалтад 24 гишүүн оролцсоноос 14 гишүүн зөвшөөрч, 58.3 хувиар энэ санал дэмжигдлээ.

2.Хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад оролцсон гишүүдийн 62.5 хувь дэмжсэнээр энэ санал дэмжигдлээ.

3.Хамт өргөн мэдүүлсэн Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад оролцсон гишүүдийн 20.8 хувь дэмжсэнээр энэ санал дэмжигдсэнгүй.

Санал хураалт явуулж дууслаа.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулсан талаар Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Мандхай гишүүн танилцуулна. Хуулийн төслийг хэлэлцэж дууслаа.

Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусаж, хуралдаан үүгээр өндөрлөж байна. Хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүд, ажлын хэсэгт баярлалаа.

17.15 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Д.ОТГОНДЭЛГЭР